

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ
/2017 оны III улирлын байдлаар/

2017.10.09

№	Бодлого арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Үнэлгээ
<p align="center">НЭГ. ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: Иргэнээ дээдэлсэн нутгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, төрийн албаны чадавх, хариуцлага, хяналтын тогтолцоог сайжруулж, гадаад харилцааны үр нөлөө хамтын ажиллагааг бэхжүүлнэ.</p>					
<p align="center">1.1 Нутгийн удирдлагын хүрээнд:</p>					
1	1.1.1.Бүх шатны төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд хамруулна. /Сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга, Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга, төрийн албан хаагчид/	Жилдээ	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.	<p>Аймгийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан 14 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадад хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу Монгол улсын хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах, Засаг захиргааны анхан шатны нэгж Багийн удирдлагыг чадавхжуулах, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог нэмэгдүүлэх, иргэдийн санал, хүсэлтийг төр, орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж, төр-иргэний харилцааг сайжруулах зорилгоор нийт 7 удаагийн чадавхжуулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан.</p> <p>“Нутгийн хөгжил сум, багаас” сургалтад 10 сумын Засаг даргын орлогч, 66 багийн Засаг дарга нарыг хамруулсан.</p> <p>Удирдлагын академийн “Нутгийн захиргааны байгууллагын эрх зүйн зохицуулалт: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалтад 14 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, мөн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино хугацааны зорилтот зайны сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын нийт 24 албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Монгол, Канад 2 улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Merit төсөлтэй хамтран "Монгол улс Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь" /MERIT/ төслийг 2016-2022 онуудад Дорнод аймагт хэрэгжүүлж байгаа юм. MERIT төслийн зорилго нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал юм.</p> <p>Төслийн хүрээнд төрийн захиргааны албан хаагчдад "Дорнод аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах" сэдэвт төлөвлөлтийн сургалтыг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зохион</p>	100

				байгуулсан. Сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүд нийт 66 холбогдох албаны хүмүүс хамрагдав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж” сургалтад 80 албан хаагчид хамрагдсан. “Иргэдийн оролцоог хангахад олон нийтийн сүлжээг ашиглах нь” сэдэвт мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Монгол хэвлэлийн хүрээлэнтэй хамтран нийт 70 албан хаагчдад зохион байгуулсан. Дорнод аймгийн нийт төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн нийт төрийн байгууллагуудад “ЭЙБЛ” программыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 14 сум, 102 төрийн байгууллагуудын Удирдах ажилтан 129, Хөтлөн удирдагч 229, Бүх нийтийн 177 албан хаагч буюу нийт 535 албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулж тус программыг үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.	
2	1.1.2.Хүний нөөцийг чадавхжуулах сургалт, төрийн байгууллагуудын туршлага солилцох уулзалтууд зохион байгуулах.	2,3 дугаар улирал	Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг хөгжүүлэх, сургалт хөгжлийн бодлого хэрэгжинэ.	Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, 14 сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн төсвийн шууд захирагч нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж, нэгдсэн үүрэг чиглэл, мэдээлэл өгөх, хүний нөөцийн ажилтан болон сумдын мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр нийт 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн төрийн байгууллагуудын туршлага солилцох нийт 21 арга хэмжээ, уулзалтад төрийн байгууллагын удирдлагууд, албан хаагчид оролцсон. “Иргэдийн оролцоог хангахад олон нийтийн сүлжээг ашиглах нь” сэдэвт мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Монгол хэвлэлийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан. Хүний нөөцийг чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор 78 удирдлага, хүний нөөцийн ажилтнууд хамрагдсан. Төрийн байгууллагуудад туршлага судлуулах, сургалтад хамруулах ажлын хүрээнд АНУ, БНСУ, ХБНГУ, Япон, Сингапур, Казакстан, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-д нийт 25 төрийн албан хаагчдыг хамруулсан. Сумдын мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад нийт 55 төрийн албан хаагч, 25 удирдлагуудыг хамруулж ажилласан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Нэмүү өртгийн сүлжээ төсөл”-ийн хүрээнд Булган аймгийн Хутаг-Өндөр суманд махны чиглэлээр фермерийн аж ахуйн эрхэлдэг аж ахуйн үйл ажиллагаа, мах боловсруулах цехийн үйл ажиллагаатай танилцсан. Энэ ажлын хүрээнд Булган аймагт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн захиралтай Дорнод аймагт мах боловсруулах, мах бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгж, малчдын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж туршлага солилцсон. Мөн НҮБ-ын “Нэмүү өртгийн сүлжээ төсөл”-ийн хүрээнд аймгийн мах, сүү, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжтэй “Нэмүү өртгийн	100

				сүлжээний платформын уулзалт"-ыг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дархан хотын Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Эрдэнэт хотын Засаг даргын Тамгын газар болон "Эрдэнэт үйлдвэр"-ийн үйл ажиллагаатай танилцсан.	
3	1.1.3."Иргэдтэй уулзах өдөр", "Нээлттэй хаалганы өдөр", "Орон нутгийн удирдлагын цаг" арга хэмжээг сум, газар, хэлтэс, агентлагуудын түвшинд зохион байгуулах	Улирал тутам	Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай, чанартай, чирэгдэлгүй хүргэх бодлого хэрэгжинэ.	Төр засгийн болон аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, төр иргэний уялдаа холбоог сайжруулан, иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулдаг "Иргэдтэй уулзах өдөр" арга хэмжээг хөдөөгийн 13 сум, Засаг даргын дэргэдэх агентлаг, хэлтсүүд улирал бүр зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус "Иргэдтэй уулзах өдөр"-т 1200 гаруй иргэд хамрагдан төрийн үйлчилгээг хүртсэн. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах, иргэдийн санал, хүсэлтийг сонсох, тэдэнд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын дэргэдэх 13 газар, хэлтэс, албадууд байгууллагын түвшинд "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 7600 гаруй иргэнд төрийн үйлчилгээг хүргэн ажилласан. Аймгийн хэмжээнд "Нээлттэй хаалганы өдөр"-ийн арга хэмжээ 2017 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Аймаг орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагууд хамтран цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нэгдсэн мэдээлэл өгөх уулзалт, удирдлагын мэдээллийн цагийг тогтмол зохион байгуулж, орон нутгийн 6 телевиз, 7 хоног тутмын хоёр сонин, цахим сайт болон аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны пэйж хуудсаар сошиал орчинд тогтмол ярилцлага, мэдээлэл өгч ажиллав.	100
4	1.1.4.Засаг захиргааны нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Сум сурталчлах өдөрлөг"-ийн арга хэмжээг зохион байгуулна.	Жилдээ	Засаг захиргааны анхан шатны нэгжийн үйл ажиллагаа иргэдэд нээлттэй, ойр ажиллах орчин бүрдэнэ.	Ардын хувьсгалын 96 жил, аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн баяр наадмаар "Сум сурталчлах өдөрлөг"-ийн арга хэмжээг хөдөөгийн нийт 13 сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан. Үр дүн: Өдөрлөгт 13 сумын нийт 260 гаруй ажилтан, албан хаагч, иргэд оролцож орон нутгийн онцлог, уламжлалт соёл, уран сайханчдын урлагийн тоглолт үзүүлэн, сумаас төрөн гарсан урлаг, соёлын алдартнууд, сумын түүх өгүүлсэн гэрэл зураг, түүх соёлын үзэсгэлэн, сумын үйлдвэрлэл эрхлэгчдийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2000 орчим иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажилласан.	100
5	1.1.5.Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйл ажиллагааны хүртээмжийг	Жилдээ	Төрийн албан хэргийн цахим орчин бүрдэнэ	www.dornod.gov.mn цахим сайтыг шинэчилж, аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргаж байгаа нийтэд хамааралтай 246 захирамж, аймгийн	100

	нэмэгдүүлэх зорилгоор шуурхай хуралдаан, бичиг баримтын хүргэлтийг цахимжуулна.			<p>удирдах ажилтны шуурхай хуралдааны 33 тэмдэглэлийг тус сайтад байршуулан ажиллаж байна.</p> <p>Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох цахим хуудас www.70582233.mn сайтаар 2017 оны 9 сарын байдлаар явсан 880, ирсэн 1042, нийт 1922 албан бичгийг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 22 агентлаг, 14 сум, 14 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хүргэн ажилласан байна.</p> <p>Үр дүн: Төрийн байгууллагуудын төсөв, цаг хугацааг хэмнэж албан бичиг, шийдвэрийг цахим хэлбэрээр түргэн шуурхай хүртээмжтэй хүргэж байна. Мөн нийт төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн нийт төрийн байгууллагуудад “ЭЙБЛ” программыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.</p>	
6	1.1.6.Олон улсын жишигт нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумын төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.	Жилдээ	Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдал хангагдана.	<p>Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудын ажлын ур чадвар, хяналт, хариуцлагыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ISO 9001:2008 стандартын шаардлагад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог бий болгож, баримтжуулж, хэрэгжүүлэх, хэвшүүлэх ажлыг байгууллагын түвшинд зохион байгуулан ажиллах тухай заалтыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 22 агентлагийн 2017 оны үр дүнгийн гэрээнд тусган ажилласан. ISO 9001:2008 стандартын хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ хийж, дүнгийн мөрөөр зөвлөмж хүргүүлж ажиллалаа.</p> <p>Үр дүн: Баянтүмэн, Булган, Дашбалбар, Чойбалсан сумд “Монголын бүтээмжийн төв”-өөс багш урьж авчран төрийн байгууллага, албан хаагчдад Олон улсын ISO 9001:2008 стандартын чанарын удирдлагын тогтолцооны сургалтуудыг зохион байгуулснаар төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сайжирсан.</p> <p>Энэ хүрээнд нийт агентлагууд аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллаж ISO:9001-2008 олон улсын стандартын туршлага судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан байна. Тухайлбал: аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Улсын бүртгэлийн хэлтэс Сар бүр тодорхой зорилт дэвшүүлэн дотоод үйл ажиллагаа, байгууллагын тохижилтыг сайжруулан ажиллаж, үр дүнг тооцсон байна. Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шинжилгээний алба нь ажлын байрны 1-3 давхрын гарах шат, хананы хэсэгт өгсөх ачааллын секунд, зарцуулах килокалори, нас, зай хэмжээг метрээр зааж өгсөн бичлэг үйлдэж бусад стандарт таних тэмдгээр хангаж, санал хүсэлтийн хайрцаг дэвтэрт бичилт хийхэд зориулан сандал, ширээ, ойрын харааны 2-3 төрлийн нүдний шил, үзгэн бал зэргийг байрлуулсан байна.</p> <p>Монгол, Канад улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Merit төсөлтэй хамтран төрийн захиргааны албан</p>	100

				<p>хаагчдад “Дорнод аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах” сэдэвт төлөвлөлтийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар болон 22 агентлагийн нийт 70 албан хаагчдыг хамруулж олон улсын чанарын удирдлагын тогтолцоог төрийн байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001-2015 стандартыг нэвтрүүлэх зорилгоор Мэрит төслийн санхүүжилтээр Австралийн баталгаажуулалтын BCERT компаниас зохион байгуулж, сургалтад нийт 16 албан хаагчдыг хамруулсан.</p>	
7	<p>1.1.7.Аймаг, сумын Засаг даргын захирамж, шийдвэрүүдийг иргэдэд нээлттэй болгож, цахим мэдээллийн санг үүсгэж ажиллана.</p>	Жилдээ	Орон нутгийн иргэдэд шийдвэр нээлттэй болсон байна.	<p>Аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргаж байгаа нийт 246 захирамж, аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдааны 33 тэмдэглэлийг www.dornod.gov.mn сайт болон “Иргэд хүлээн авах төв”-д байршуулан мэдээллийн санг үүсгэн, иргэдэд мэдээлэн ажиллаж байна.</p> <p>Үр дүн: Төрийн байгууллагуудаас гаргаж байгаа шийдвэр иргэдэд нээлттэй, хүртээмжтэй болсон. Мөн www.dornod.gov.mn сайтад байршуулсан мэдээллийг давхардсан дүнгээр нийт 310,315 иргэн авч, “Иргэд хүлээн авах төв”-д 378 иргэн хандаж мэдээлэл авсан.</p>	100
8	<p>1.1.8.Төрийн байгууллагуудын ажил, үйлчилгээ, албан хаагчдын ажлын байрны чиг үүргийг ил тод болгож, ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулна.</p>	Жилдээ	Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ил тод нээлттэй, хүртээмжтэй болно.	<p>Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын танилцуулга, мэдээллийн нэгдсэн сан үүсгэж 22 агентлаг, 3 соёлын байгууллагаас хүний нөөцийн судалгааг авч нэгтгэн, төрийн байгууллагуудын бүтэц, ажлын байрны чиг үүргийг шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн албан хаагчидтай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Хувийн хэрэг” нэгдсэн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны А/157 дугаар захирамжаар төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагуудын бүтцийг төсвийн захирагч бүрээр уялдуулан боловсруулах, хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Үр дүн: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог шинэчлэн баталж ажлын байрны чиг үүргийн давхардал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсан. “Хувийн хэрэг” сарын аяны хүрээнд 22 агентлаг, 3 соёлын байгууллага, 14 сум нийт 67 удирдах ажилтны хувийн хэргийг шинэчлэн боловсруулалт хийж бүрдүүлсэн.</p>	70
1.2 Гадаад харилцааны чиглэлийн хүрээнд:					

9	1.2.1.Дорнод аймаг, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Хянган аймаг, Шилийн гол аймаг, Манжуур хоттой хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.	Жилдээ	Дорнод аймаг, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Хянган аймаг, Шилийн гол аймаг, Манжуур хотуудтай хамтын ажиллагааны баримт бичигт тусгагдсан ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнд хүрнэ.	Аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид 2017 оны 5 дугаар сард ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотод ажлын айлчлал хийж холбогдох удирдлагуудтай уулзалт зохион байгуулан “Монгол улсын Дорнод аймаг, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн салбарт 2017-2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тэргүүтэй төлөөлөгчид 2017 оны 4 дүгээр сард Дорнод аймагт албан айлчлал хийж, айлчлалын үеэр аймгийн холбогдох газар, хэлтэстэй танилцаж, туршлага солилцсон бөгөөд аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Борзя хотод айлчлал хийж тус хотын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид 2017 оны 8 дугаар сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хот, Хөлөнбуйр хот, Хянган аймгуудад албан айлчлал хийж, хоёр орон нутгийн хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хэлэлцээрт гарын үсэг зурсан. Аймгийн Засаг даргын орлогчтэргүүтэй төлөөлөгчид “Хятад улс, Хайлаарын 13 дахь удаагийн Монгол, Хятад, Оросын эдийн засаг, худалдааны уулзалт бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа” арга хэмжээнд оролцсон. Тус үзэсгэлэн худалдаанд Дорнод аймгийн 8 аж ахуйн нэгж оролцон, бараа бүтээгдэхүүнээ танилцуулж, нийт 30 орчим сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн Дорнод аймгийн нэг аж ахуйн нэгж Хайлаар хотын аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Үр дүн: 2017 онд хөрш зэргэлдээ хоёр улсын хамтын ажиллагаатай аймаг, хотуудад ажлын айлчлал хийж, хамтын ажиллагааны хэлэлцээрийг шинэчлэн байгуулсан бөгөөд хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг, салбар хороодыг байгуулан, бэлтгэлийг ханган ажиллаж байна.	100
10	1.2.2.БНХАУ-ын Зүүн хойд гурван муж болох Хар Мөрөн, Жилин, Ляонин муж болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунглио, Улаанхад хоттой харилцаа тогтоож, худалдаа, эдийн засаг, аялал жуулчлал, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Жилдээ	Нийгэм, эдийн засгийн тодорхой салбарт хамтран ажиллах эхлэлийг тавьж, хамтын ажиллагааг хөгжүүлэн үр дүнд хүрсэн байна.	Аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын Хармөрөн мужийн Хэйхэ хотод 2017 оны 8 дугаар сард Их Түмэн Санаачилгын Зүүн хойд Азийн орон нутгийн хамтын ажиллагааны хорооны 5 дугаар хурал, логистикийн дэд хорооны 3 дугаар хуралд оролцсон. Хурлын үеэр Их түмэн санаачилгын салбар хороо, хувийн хэвшлийн төлөөллийн хамтын ажиллагааны талаар санал солилцож, Дорнод аймгаас хэрэгжүүлэх саналтай байгаа Аялал жуулчлал, Авто замын Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг, БНХАУ-ын Тунглюо, Улаанхад хот, Шилийн гол аймгийн зургаан талт уулзалт 9 дүгээр сарын 21-23-ны өдөр Улаанхад хотноо зохион байгуулагдаж, аймгийн Засаг даргын орлогч тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. Дээрх уулзалтад тус аймаг, хотуудтай хамтран ажиллах саналаа танилцуулж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.	70

				Үр дүн: Санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг, салбар хороодыг байгуулан, хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна.	
11	1.2.3.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Их Түмэн Санаачилга /GTI/, Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбоо /NEAR/, бусад Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Жилдээ	Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, орон нутгийн ашиг сонирхлыг бүс нутгийн түвшинд илэрхийлнэ.	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотноо 2017 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Их түмэн санаачилгын Зүүн хойд азийн Орон нутгийн хамтын ажиллагааны хорооны 5 дугаар хурлын бэлтгэл ажлын хурал, Логистикийн дэд хорооны ажлын уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцож, “Чойбалсан хотоос Хавирга боомт, Халхгол сум, Ульхан боомт хүртэл хатуу хучилттай авто зам тавих” төсөл, “Дорнод Монголын шилтгээн” аялал жуулчлалын төслийг танилцуулж, Аялал жуулчлалын дэд хороо болон Авто тээврийн хороонд төслүүдийг хүргүүлсэн. Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбоо /NEAR/-ны зүгээс БНСУ-ын Жэжү хотноо зохион байгуулагдсан Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Гёнсанбүг мужийн Андун хотноо зохион байгуулсан Эдийн засаг, хүмүүнлэгийн харилцааны хорооны 12 дугаар хурал, Дэжон хотноо зохион байгуулсан “Ази, Номхон далайн орнуудын хотын захирагч нарын форум-2017” зэрэг арга хэмжээнүүдэд аймгийн төлөөллүүд оролцож, Холбооны салбар хороонд зохицуулалт хийх тухай, Салбар хороодыг байгуулах болон ажиллуулах тухай журмын агуулгад өөрчлөлт оруулах тухай, Гишүүний татварын зарцуулалтын асуудлыг шийдвэрлэх, аймаг, хотын соёлын өвийн онцлогийг түшиглэн нийтэд сурталчлан таниулах, улмаар аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг асуудлаар аймаг, орон нутгийн саналаа танилцуулсан. Үр дүн: Дээрх холбоодын гишүүн орон нутгуудад аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдал, хөгжлийн хэтийн чиг хандлагын талаар сурталчлан таниулж ажиллаж байгаа бөгөөд Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааны хорооны Логистикийн дэд хороонд гишүүнээр элсэж, цаашид хорооны гишүүн орнуудтай илүү үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бүрдсэн.	100
12	1.2.4.Япон улсын Фүкуока мужтай тогтоосон харилцааг худалдаа, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүч, шинжлэх ухааны салбарт идэвхтэй хөгжүүлнэ.	2,3 дугаар улирал	Нийгэм, эдийн засгийн салбарт хамтран ажиллах эхлэлийг тавьж, тодорхой үр дүнд хүрсэн байна.	Япон улсын Фүкуока мужтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүсэлтээ илэрхийлж, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалан, худалдаа үйлчилгээ, нийгэм хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах саналуудаа хүргүүлсэн бөгөөд Фүкуока мужийн зүгээс хамтран ажиллах боломжтой салбарыг тодорхойлон, хариу ирүүлэх хүсэлтийг хүргүүлээд байна.	40
1.3 Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:					

13	1.3.1.Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлдэг Холбогдох эрх зүйн акт, мэдээ, тайлангийн биелэлт, боловсруулалтад тавих хяналтыг сайжруулах үүднээс аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдын удирдлагууд, Хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий “Журам” боловсруулан хэрэгжүүлнэ.	Жилдээ	Журмыг боловсруулан батлуулснаар аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдаас аймгийн ЗДТГ-т ирүүлдэг мэдээ, тайлангийн бүрдэл, боловсруулалтад ахиц гарч, хариуцлагын тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна.	Орон нутгийн зүгээс бие даасан журам боловсруулахгүй, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зөвлөсний дагуу Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг албан хэрэгцээнд ашиглаж байна.	70
1.4 Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:					
14	1.4.1.Иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн албан болон албан бус сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Жилдээ	Иргэдийн хууль, эрх зүйн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэнэ	Аймгийн хэмжээнд эрх зүйн сургалт сурталчилгааны чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2017 оны төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 35 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 940 гаруй төрийн албан хаагчдад Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль тогтоомжуудаар тус тус сургалт зохион байгуулсан. Мөн Чойбалсан сумын 53, Хэрлэн сумын 7 багийн 41, аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Албадан эрүүлжүүлэх байранд саатуулагдсан 350 гаруй иргэдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт мэдээллийн ажил зохион байгуулсан. Аймгийн аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газраас иргэдийн өмчийн хулгайгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагч бүр 1 аж ахуй нэгж, байгууллага хариуцан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж сурталчлах сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан бөгөөд тус сургалт мэдээллийн ажилд 18 банк санхүүгийн байгууллага, архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 71 аж ахуй нэгж байгууллага, 24 шатахуун түгээх станц нийт 113 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиудын сургалтыг 2017 оны 5 дугаар сарын	70

				19-23-ны өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулсан. Тус 5 өдрийн сургалтад аймгийн хууль хяналтын байгууллагын 120 албан хаагч хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2017 оны А/196 дугаар захирамжаар “Хил орчмын бүс нутагт нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үеийн хамтын ажиллагаа” сэдэвт хамтарсан команд штабын сургуулилтыг хууль хяналтын байгууллагууд хамтран 2017 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтыг зохион байгуулснаар хууль хяналтын байгууллагууд онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцан ажиллах хамтын ажиллагаагаа тодотгосон.	
15	1.4.2.Иргэд, олон нийтийн хүний эрхийн талаарх боловсролыг нэмэгдүүлэн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны үр дүнг сайжруулна.	Жилдээ	Орон нутгийн хэмжээнд иргэдийн болон төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт нэмэгдэнэ	Иргэд, олон нийтийн хүний эрхийн талаарх боловсролыг нэмэгдүүлэн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр Хүний эрхийн үндэсний комиссын Дорнод аймаг дахь ахлах мэргэжилтэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 15 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 53 оюутан, аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 25 албан хаагч, Мэргэжлийн хяналтын газрын 25, Онцгой байдлын газрын 61, Зэвсэгт хүчний 0327 дугаар ангийн 112, Хилийн 0132 дугаар ангийн 90 хугацаат цэргийн албан хаагчид болон Хэрлэн сумын 7 дугаар багийн 41 иргэнд хүний эрхийн ойлголт, хандлага сэдвүүдээр сургалт мэдээллийн ажил зохион байгуулсан. Хүний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлын хүрээнд хүний эрхийн зөрчилтэй холбоотой 3 гомдлыг ХЭҮК-д бүртгүүлэн гомдол хянан шалгах ажиллагааг хийж байна. Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байрны үйл ажиллагаа болон ахуй нөхцөлд Хүний эрхийн үндэсний комиссоос баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажил зохион байгуулан зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.	70
16	1.4.3.Аймгийн эрүү хэв журмын 2016 оны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, өссөн үзүүлэлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Жилдээ	Гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан байна.	Аймгийн эрүү хэв журмын 2016 оны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, өссөн үзүүлэлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны 4 дүгээр албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор тодорхой төрлийн гэмт хэрэг өсөлттэй байгаа баг, сумын Засаг дарга нарт чиглэл өгсөн аймгийн Засаг даргын 2017 оны А/303 дугаар захирамжийг гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд “Камер хяналт”, “Харуул манаа хамгаалалт”, “Иргэдийн өмчийн хулгай-илрүүлэлт”, “Олон нийтийн эргүүл”, “ Оюутан эргүүл”, “Халтиргаа гулгаа”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсооё”, “Шатахуун түгээх станц-Хяналт”, “Эргүүл-Хяналт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж нийт 252 байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчдад сургалт мэдээлэл зохион	70

				байгуулаад байна. Дээрх нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр телекамертай болох мэдэгдлийг 28 банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газруудад хүргүүлээд байна. Улсын хилээр хууль бусаар архи согтууруулах ундаа оруулах, иргэдэд зөвшөөрөлгүй зарж борлуулах зөрчлийг илрүүлэх зорилгоор “Архи-Хяналт”, “Эрүүл хүнс-хяналт”, “Бажу архи-илрүүлэлт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дарсны үйлдвэр 1, дэлгүүр бөөний төв 184, ресторан зоогийн газар 6, диско, караоке баар 26, кафе 13 тус тус хамрагдан шалгагдсан. Хяналт шалгалтаар Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, аймгийн Засаг даргын А/444 дүгээр захирамжаар тогтоосон цагийн хязгаарыг зөрчсөн нийт 45 зөрчил илрүүлж 41 иргэн, 4 аж ахуйн нэгжид 1.087.000 төгрөгийн торгууль, хууль бусаар зарж борлуулж байсан 813 литр архийг хураан авч устгалд оруулж холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэн биелэлт үр дүнг тооцон ажилласан. Аймгийн хэмжээнд 2017 оны 03 дугаар улирлын байдлаар 361 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
17	1.4.4.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулна	Жилдээ	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг батлагдсан байна.	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газартай хамтран “Замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Тус хөтөлбөрийн төслийг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн тэднээс санал авах ажлыг зохион байгуулах чиглэлийг аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт 2017 оны 7 дугаар сард хүргүүлээд байна.	40
18	1.4.5.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэн насанд хүрээгүй хүүхэд гэмт хэргийн хохирогч, холбогдогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэгт холбогдож буй хүүхдүүдийн нэгдсэн мэдээллийн дата баазтай болох ажлыг зохион байгуулна.	Жилдээ	Хүүхдийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа эрчимжиж насанд хүрээгүй хүүхэд гэмт хэргийн холбогдогч болж буй байдалд тавих хяналт сайжирна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн Засаг даргын 2017 оны А/201 дүгээр захирамжаар байгуулаад байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын мэргэжилтэн анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн 16 хүүхдийн батлан даагчаар оролцон холбогдох байгууллагад ял хойшлуулах хүсэлтийг гаргаад байна. Аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдож гэмт хэргийн хохирогч, холбогдогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хяналтыг сайжруулах зорилгоор гэмт хэрэгт холбогдож буй хүүхдүүдийн нэгдсэн мэдээллийн дата баазыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 1,000,000 төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгүүлэн аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын	70

				хөгжлийн газарт хүлээлгэн өгөөд байна. Тус програмд гэмт хэрэг зөрчилд холбогдсон 13 хүүхдийн мэдээллийг оруулан бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна.	
19	1.4.6.“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, архидаан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн үйл ажиллагааг сайжруулан байгууллага хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн сайжирна	“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/191 дүгээр захирамжаар архи согтууруулах ундаа, хорт зуршлын эсрэг “Эрүүл нийгэм-Таны оролцоо” аяныг зарлан 30 бүтээлч ажил арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд 9 иргэнийг архинаас гаргах албадан эмчилгээнд хамруулж, архины хамаарал бүхий 83 иргэнийг үзлэг оношилгоонд оруулан шаардлагатай бичиг баримттай болгосон. Мөн 3 иргэнийг байнгын ажлын байртай болгон 90 иргэнийг архинаас гаргах сайн дурын эмчилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд согтууруулах ундааны хэрэглээний сөрөг үр дагаврыг иргэдэд ухуулан нөлөөлөх, эдгээр хорт зуршил нь хувь хүн, хүүхэд гэр бүл, нийгэмд ямар сөрөг нөлөө үзүүлж байгааг ойлгуулах зорилготой нийтийг хамарсан нөлөөллийн 13 ажил, арга хэмжээг зохион байгуулж, 10,000 гаруй иргэдийг тус үйл ажиллагаанд хамрууллаа. Нэгдсэн хяналтын шалгалтын хүрээнд хууль бусаар худалдан борлуулсан 813 литр спиртийг устгаад байна. Мөн архи согтууруулах ундаа хорт зуршлын эсрэг сургалтыг 12 байгууллагын 355 ажилтан, албан хаагчдад зохион байгуулаад байна. Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлсний үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 86 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 33 нэгж буюу 27,7 хувиар буурч, согтуугаар зөрчил гаргаж саатуулагдсан иргэдийн тоо 349 нэгж буюу 11,7 хувиар буурсан байна.	70
20	1.4.7.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр байгууллага, иргэдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн улсын хил хамгаалалтад татан оролцуулах, хилчид, хил орчмын ард иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулна.	Жилдээ	Хил орчмын бүсэд амьдарч буй иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн идэвх оролцоо сайжирна	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Хилийн 0132 дугаар анги дээр зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний Зөвлөлийн 13 гишүүн, хилийн 4 анги, хилийн сумын Засаг дарга 7, сумын Засаг даргын Тамгын газрын дарга 3, багийн Засаг дарга 8, хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн гишүүн малчид 30, нийт 67 Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн гишүүд болон малчид оролцсон бөгөөд тус арга хэмжээний хүрээнд “Нээлттэй хэлэлцүүлэг” зохион байгуулж, аймаг, сумын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, хилийн ангиудад чиглэл өгсөн зөвлөмжийг боловсруулан гаргасан. Мөн нэгдсэн зөвлөгөөнд оролцсон 67 Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн гишүүдэд шинэчлэн батлагдсан Хилийн тухай хуулийн сургалт зохион байгуулж иргэдийг хил хамгаалалтад татан оролцуулах журам, Хууль зүйн сайдын 1/1 албан даалгавар болон зөвлөгөөнд хэлэлцүүлсэн илтгэл, хичээлүүдээр эмхэтгэл, гарын авлага боловсруулж зөвлөгөөнд оролцогчдод өгч ажилласан. Мөн аймгийн хэмжээнд 2017 онд 25 иргэн хил хамгаалалтад	100

				туслах хүчний гишүүнээр элсэж үнэмлэхээ гардан авсан. Тус ээлжит зөвлөгөөнөөс 3 чиглэлийн хүрээнд 28 заалт бүхий зөвлөмжийг гарган хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна. Хил орчмын бүсэд амьдарч буй иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Хил хамгаалах ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу хилийн 4 ангиуд сар бүр хил орчмын бүс, зурваст амьдарч байгаа иргэдэд хууль тогтоомжийн мэдээлэл өгч хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил гаргахгүй байх баталгааг гаргуулан авч хэвшээд байна. Мөн Хил орчмын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд болон хилчдэд Хилийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгох сургалтыг 2017 оны 6 дугаар сарын 25-наас 8 дугаар сарын 20-ныг хүртэл хугацаанд 9 застав 1 боомтын хариуцсан хэсэгт зохион байгуулсан. Тус сургалтад хил хамгаалах байгууллагын 172 албан хаагч 84 иргэн хамрагдсан.	
21	1.4.8.Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг орон нутагт зохион байгуулж, төрийн байгууллага, албан хаагчдын манлайллыг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Төрийн байгууллага, албан хаагч болон иргэдийн хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна.	Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг танилцуулан төрийн байгууллага, албан хаагчдын манлайллыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн танилцуулгыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Дорнод Нийтийн аж ахуй Орон нутгийн өмчит аж ахуйн тоцоот үйлдвэрийн газар, Хилийн 0132 дугаар анги, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 425 ажилтан, албан хаагчдад зохион байгуулаад байна.	70
22	1.4.9.“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн III дугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэх, төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийсэн байдлыг нягтлан шалгаж, данс бүртгэлийг шинэчлэн сайжруулах, цахим болон тоон хэлбэрт оруулах, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.	Жилдээ	Цаасан суурьт баримтыг цахимжуулах хөмрөг үүсгэгч байгууллагуудын тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг нь 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, цахимжуулах ажлын сар улирал өдөр тутмын үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. 2017 оны эхний 9 сарын байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 10 хөмрөгийн 10 дансны 441 хадгаламжийн нэгжийн 53537 хуудас баримтыг шивж байршуулав. Цахим холболт- 441 хадгаламжийн нэгжийн 53537 хуудас баримт, Хүний нэр-267987, Байгууллагын нэр-2967, Газар зүйн нэр-3628, Заалт 59154-ыг оруулсан. Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд Аймгийн Засаг даргын нөөцийн сангаас 800,0 мянган төгрөгийн дэмжлэг авч Архивын Ерөнхий газраас нягтруулсан шүүгээ болон баримт зөөвөрлөх, хамгаалалтын хайрцаг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	70

1.5 Батлан хамгаалах салбарын хүрээнд:				
23	1.5.1.Монгол улсын Их хурлаар шинээр батлагдсан Батлан хамгаалах салбарын багц хууль тогтоомжийг орон нутагтаа сурталчлан хэрэгжүүлэх биелэлтэд хяналт тавин ажиллана.	Жилдээ	Аймгийн хэмжээнд батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газартай хамтран батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомж орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдалтай танилцаж, заавар зөвлөмж өгч шалган туслах ажлыг зохион байгуулав. Үүнд: Хэрлэн сумын 10 багийн Засаг даргын ажлын алба нийт 23 ааеаооёёагын аүйёдүйе 22 дүйдүй дөиддөааасан. Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Засгийн Газрын 2008 ийы 49 аүйеэд дөиддөиддөа цэргийн дүйцүүлэх албыг хаалгахаар Хэрлэн, Цагаан-Овоо суманд 15 дөдүйи дөаае, нөиддүйи Цагаан ааддүйи дөдөддүйи, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг 22 дүйдүйи Цүдүйи дөдөддүйи дөиддөиддүйи цэргийн дүйцүүлэх албанд татан авсан.</p> <p>Ииддүйи Оөддүйи 2009 оны 33 дугаар тогтоол, Ииддүйи Оөддүйи Цагаан ааддүйи 2017 оны 51 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ииддүйи дөдөддөддүйи дүйддөддүйи дөддөддүйи 118 иргэний 12,0 сая төгрөддөддүйи төлүүлж, 55 иргэнийг ииддүйи дөдөддөддүйи дүйддөддүйи дөддөддүйи дөддөддүйи дөддөддүйи дөддөддүйи чөлөөлсөн. Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэргийн жинхэнэ алба хаагаагүй 101 иргэнд 30,0 сая төгрөгийн мөнгөн төлбөрийг тогтоогоод байна.</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2008 ийы 194 аүйеэд дөиддөиддөа хэрэгжүүлж, “Гэрээт цэрэг-Ажлын байр” төлөвлөгөөний дагуу “цэргийн албыг сайн дурын үндсэн дээр” элсүүлэх ажлыг зохион байгуулж гэрээт цэргийн албанд 4 иргэнийг элсүүлэн дөдөддүйи цэргийн анги салбаруудад хуваарилан алба хаалгаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 40 дүгээр тогтоол, Батлан хамгаалах сайдын 2016 оны А/33 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/93 дугаар захирамжийн дагуу “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах орон нутаг дахь их, дээд сургуулиудын бакалаврын өдрийн ангид суралцаж байгаа нэгдүгээр дамжааны оюутнуудаас сайн дурын үндсэн дээр алба хаах залуусыг сургалтын алба, сургуулийн тодорхойлолтоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаар дамжуулан гуравдугаар сарын 15-наас 4 дүгээр сарын 1-ний хооронд бүртгэлийн ажлыг зохион байгуулан явуулж, нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдан 30 оюутан цэргүүд тэнцэж цэргийн анх шатны бэлтгэл сургалтад хамруулсан. Тус сургалтад Дорнод аймгаас 30, Говьсүмбэр аймгаас 12, Улаанбаатар хотоос 8 оюутан цэрэг нийт 50 цэргийн алба хаагчийг хамрагдсан. Түүнээс явцын дунд өвчний улмаас 3 ЦАХ зохих журмын дагуу цэргийн албанаас чөлөөлөгдсөн. Сургалтын төгсгөлд оюутан цэргүүд тангараг өргөж, дайчилгааны бэлтгэл нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэн, цэргийн мэргэжлийн дугаар хүлээн авсан.</p>

24	1.5.2.Чулуунхороот, Гурванзагал сумдын батлан хамгаалах товчооны томилгоот бүрэлдэхүүн, оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтнүүдтэй дайчилгааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх үеийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгт дадлагажуулах сургалтыг зохион байгуулна.	2 дугаар улирал	Батлан хамгаалах товчооны бүрэлдэхүүний бэлэн байдлын дэд зэргүүдэд шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, үүрэгт нь дадлагажуулна	Ийгэе Уеһиү Ааоёаи оаiaааёао оооаё оооёеёе 4 а́а́уу́ а́еёеёе 17 а́оаа́а́д а́еёеёе 17.1.1, 17.1.6, о́уоаёеё а́еаа́и́у оооаё ооооёеёе 8 а́оа́а́а́д а́еёеёе 32.1 а́а́уу́д а́еёе, “Аае+еёааа́и́у оооаё” Ийгэе Уеһиү хуулийн 5 а́оа́а́а́д а́еёеёе 29 а́а́уу́д а́еёе, Аеiaеёе Цаһаа́ а́а́д́и́у 2017 и́и́ А/07 дугаа́д а́оёёоа́еуудыг үндэслэн Дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг нийт 60 бэлтгэл үүрэгтэнтэйгээр Цуаһуа́о о́е-iee 327 а́оа́а́а́д а́ie, А́оо́а́iа́eа́e, хоёоо́oíóííò сума́а 2017 и́и́ 3 а́оа́а́а́д һа́д́и́у 06-16-и́у а́д́е́е́а́у́а́ зохион байгуулж автын о́оёёе́а́а́i-е́i мэргэжлээр 20, Ieííi,òúí а́о́oíу а́оёёо́а́e- мэргэжлээр 10, Артиллерийн тооцоочин мэргэжлээр 10, сапёрчин мэргэжлээр 20 үүрэгтэнг шинээр iу́д́а́у́æеё́ iе́áiв.	100
25	1.5.3.Зүүн аймгуудын болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулна.	3 дугаар улирал	Сургалт зохион байгуулагдаж, Тамгын газрын дарга нарын цэргийн хэргийн мэдлэг дээшилнэ.	Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын дагуу Зүүн бүсийн Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сургалтын нэгдсэн төлөвлөгөө, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг дарга нартай 2017 онд хамтран ажиллах гэрээ, Батлан хамгаалах яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2017 оны 8 дугаар сард Хилийн 0146 дугаар ангийг түшиглэн амжилттай зохион байгуулагдав. Зүүн бүсийн 4 аймгийн 76 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар тус сургалтад хамрагдах ёстойгоос 59 хүн буюу 78 хувь нь хамрагдав. Сургалтын 2 дахь өдөр “Дайчилгаа зарласан үед сумын батлан хамгаалах товчооны ажиллагаа” сэдвээр бүлгийн дасгал боловсруулав. Сургалтын удирдлагын бүлгээс стратегийн даалгавар, “А” улсын Ерөнхийлөгчийн зарлиг, аймгийн Батлан хамгаалах газрын даргын захирамж зэргийг бүлгийн дарга нарт гардуулснаар дасгал эхэлсэн ба улмаар бүлгүүд цагийн байдлыг тогтоон, Батлан хамгаалах товчооны даргын шийдвэрийн хувилбарыг боловсруулж, товчооны даргын захирамж, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Сургалтын хугацаанд бие бүрэлдэхүүн асуудал дэвшүүлэх, харилцан ярилцах, санал бодлоо илэрхийлэх, туршлага солилцох зэргээр идэвхтэй оролцсон.	100
26	1.5.4.Өсвөр үе, залуучуудыг цэрэг эх оронч үзэлтэй, эх орноо батлан хамгаалах бэлтгэлтэй залуус болгон төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Жилдээ	Цэрэг эх оронч үзэлтэй, эх орноо батлан хамгаалах бэлтгэлтэй залуус болон төлөвшинө.	Цэрэгжилт спортын “ДӨЛ” тоглолтыг 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулж Дорнод аймгийн туг, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын тугийг мандуулан баг тамирчдыг жагсаан Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн гардан тулааны үзүүлэх тоглолт, урлагийн номер үзүүлэн нээлтийн арга хэмжээ зохион байгуулсан. Тэмцээнд аймгийн төвийн Ерөнхий боловсролын зургаан сургууль, Баяндун, Баянтүмэн, Чойбалсан сумын Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 11 багийн 600 гаруй тамирчид оролцож Батлан хамгаалах хууль, тогтоомжоор хууль эрх зүйн сорилын шалгалт, жагсаалч тасаг шалгаруулах, цэргийн 16 тоот дасгал, эмнэлгийн анхны тусламжийн норматив, тасгийн захирагч нарын дунд	100

				тэмцээн, буухиа тэмцээн, цогцолбор дасгал, урлагийн номер, ханын сонин гэсэн төрлүүдээр авхаалж самбаа сорин өрсөлдсөн. Тэргүүн байр эзэлсэн баг тамирчид батлан хамгаалах сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах ДӨЛ-2017 цэрэг спортын тэмцээнд 21 аймаг 3 дүүрэг нийт 24 баг тамирчид оролцсоноос Дорнод аймгийн баг тамирчид тусгай байр эзэлсэн.	
27	1.5.5.Зэвсэгт хүчний 338 дугаар анги, Хилийн 0146 дугаар ангид Хугацаат цэргийн алба хааж байгаа дайчидтай уулзах орон нутгийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулна.	1 дүгээр улирал	Хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг эргэх орон нутгийн үйл ажиллагааг сурталчлах ажил хийгдсэн байна.	Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний барилга инженерийн 338, Хилийн 0146 дугаар ангид алба хааж байгаа дайчидтай 8 дугаар сард Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын дарга, бусад албаны хүмүүсийн хамт уулзаж аймаг орон нутагт зохион байгуулж буй цаг үеийн талаар мэдээлэл хийж, цаашдаа цэргийн албаа амжилт хаахыг хүсч дурсгалын зүйл гардуулав.	100
1.6 Гамшгаас хамгаалах бодлогын хүрээнд:					
28	1.6.1.Сумдын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангиудын гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор “Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургууль”-ийг 2 суманд, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын үзлэгийг сумдад зохион байгуулна	2,3 дугаар улирал	Сумын орон тооны бус Онцгой байдлын штаб, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллагын удирдах бүрэлдэхүүний гамшгийн удирдлагын мэдлэг дээшилж, тэдний харилцан хамтын ажиллагаа сайжирч гамшиг гарсан үед шуурхай арга хэмжээ авч ажиллах ур чадвар дээшилнэ.	Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай” хууль, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, аймгийн Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Гамшгаас хамгаалах Иж бүрэн болон Команд штабын дадлага, сургууль зохион байгуулах тухай” А/265 дугаар захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг Хөлөнбуйр суманд Бүсийн төв аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс томилогдсон ажлын хэсэг 2017 оны 6 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн удирдлага, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан ажиллагаа” сэдвүүдээр астрономын 48, оперативын 120 цагийн багтаамжтай 3 үе шаттайгаар зохион байгуулав. Хөлөнбуйр суманд зохион байгуулсан гамшгаас хамгаалах команд штабын дадлага, сургуульд Бүсийн төв аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс мэргэжлийн чиглэлээр онолын болон танхимын дадлага, сургалт зохион байгуулсан нь нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гамшиг, гал түймэр, аюулт үзэгдэл тохиолдсон үед бие даан үүрэг гүйцэтгэх үеийн удирдлага зохион байгуулалтаар хангах мэдлэг, дадлага олгосон үр дүнтэй сургууль боллоо гэж сумын удирдлагаас дүгнэсэн байна. Мөн Гамшгаас хамгаалах Иж бүрэн дадлага, сургуулийг Чулуунхороот суманд Зүүн бүсийн төв, аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс томилогдсон ажлын хэсэг 2017 оны 9 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн удирдлага, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан ажиллагаа” сэдвээр астраномийн 48, оперативийн 120 цагийн	100

				багтаамжтай 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтанд сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн нийт 64 албан хаагч оролцлов.	
29	1.6.2.Хил орчмын гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хөрш зэргэлдээ улсын ижил үүрэгтэй байгууллагатай байгуулсан дадлага, сургалтын хамтран ажиллах гэрээг дүгнэх, сунгах уулзалт, зөвлөгөөн зохион байгуулна.	2 дугаар улирал	Хил орчмын бүсэд гарсан гамшгийн үед хамтран ажиллах, мэдээлэл солилцох, шуурхай хариу арга хэмжээ авах, харилцан дэмжлэг тусалцаа үзүүлэх ажил сайжирна.	Зүүн бүсийн төв, аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын даргаар ахлуулсан Баян-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 53 дугаар ангийн 5 алба хаагч, Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаарын Акша районы Гал унтраах ангийн 5 албан хаагчид оролцсон ой, хээрийн түймрийг унтраах дадлага сургуулийг Монгол улсын хилийн 881 дүгээр тэмдэгтээр Оросын Холбооны Улс руу хилийн хялбаршуулсан журмаар нэвтэрч хилийн зурваст зохион байгуулав. Сургалтын явцад Оросын холбооны улсад ашиглагдаж байгаа гал унтраах автомашин, гал унтраах багаж зэвсэглэмжтэй танилцсан.	100
ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:					
2.1 Эрүүл мэндийн хүрээнд: Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагыг төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг сайжруулж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлнэ.					
30	2.1.1.Зарим шаардлагатай сумын эрүүл мэндийн төвийн халаалтын системийг сайжруулна.	Жилдээ	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх хэвийн нөхцөл бүрдэнэ.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтын II.2.2-т батлагдсан “Сумдын эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн халаалтын засвар” бүлгийн багц санхүүжилтээс Булган сумын Эрүүл мэндийн төвийн халаалтын тогоог шинэчлэн засварлахаар 29,2 сая төгрөгийн зураг төсөв хийлгэсэн бөгөөд засварын ажлын гүйцэтгэгчээр “Элтрүүд” ХХК шалгарч, ажил бүрэн хийгдээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баяндун /56,6 сая/, Гурванзагал /23,2 сая/ сумдын эрүүл мэндийн төвийн халаалтын тогооны засварын ажил бүрэн хийгдсэн.	100
31	2.1.2.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ /компьютер томограф/	1 дүгээр улирал	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Компьютер томографийг шинэчлэхээр орон нутгийн хөгжлийн сангаас 200,0 сая төгрөг батлагдсан боловч улсын төсвөөс нэмэлт дэмжлэг шийдвэрлэгдээгүй тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит IY хуралдаанаар дээрх хөрөнгийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 4D ЭХО аппарат авах хөрөнгийн дэмжлэг үзүүлэхэд 85,0 сая төгрөг болгон тодотгосон. Үүний дагуу 4D ЭХО аппаратын техникийн тодорхойлолтыг аймгийн Засаг даргаар батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэгчээр “Сүвэн Уул” ХХК шалгарсан бөгөөд хугацаандаа гэрээ байгуулаагүйгээс гэрээ хойшлогдоод байна.	40
32	2.1.3.Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон сум дундын эмнэлэгт шүдний эмчилгээний зориулалттай тоног төхөөрөмж худалдан авч, шүдний кабинетуудыг нээн, хүн амын дунд үзлэг оношилгоо,	Жилдээ	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.	Шүдний эмчилгээний бор аппаратуудыг худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж гүйцэтгэгчээр “Сүвэн Уул” ХХК шалгарч гэрээ байгуулан Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Баян-Уул, Халхгол сумын Сум дундын эмнэлгүүдэд нийт 3 аппаратыг суурилуулсан бөгөөд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн шүдний кабинетаар 320 хүн, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 8280 хүүхэд хамрагдсан бөгөөд нийт 8600 хүнд үйлчлээд байна.	70

	эмчлэн эрүүлжүүлэлтийг зохион байгуулна.				
33	2.1.4.18-35 насны иргэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, ярилцлага, хэлэлцүүлэг, чөлөөт үйл ажиллагааг мэргэжлийн багтай хамтран зохион байгуулна.	Жилдээ	Залуучуудын эрүүл мэндийн боловсролын хүртээмж нэмэгдэж аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдээллээр хангагдана.	Хэрлэн сумын 1, 2, 8 дугаар багийн зорилтот бүлгийн нийт 60 иргэнд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр 3 өдрийн сургалт зохион байгуулж, “Мянган жаргалан”, “Ягаан цээнэ” өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран эмэгтэйчүүд, зүрх судас, эхо, төрөлжсөн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг 320 иргэнд хүргэснээс 15 үйлчлүүлэгчийг хоёр дахь шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмсэн эмэгтэйчүүд болон тэдгээрийн гэр бүлд зориулсан эрүүл мэндийн зөвлөгөө өгөх сургалт, дасгалыг нийт 571 жирэмсэн эмэгтэйчүүдэд зохион байгуулсан.	70
34	2.1.5.Өсвөр насны хүүхдүүдэд Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.	Жилдээ	ЕБС-ийн ахлах ангийнхан болон оюутан залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг нэмэгдэнэ.	Аймгийн ерөнхий боловсролын 8 сургуулийн 8-12 ангийн 890 гаруй сурагчдад Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх сургалтыг 12 удаагийн давтамжтайгаар, үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулсан. Залуучуудын хөгжлийн төвийн амьдрах ухааны багш, Y-PEER клубын сайн дурын идэвхтэн гишүүд хамтран “Хүрч очих үйлчилгээ”-гээр дамжуулан Хэрлэн сумын байнгын асаргаатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнд амьдрах ухааны болоод Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх цуврал сургалтуудыг хүргэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох үе тэнгийн сургагч багш бэлтгэх” цуврал сургалтуудыг зохион байгуулж Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн 25 сурагчдыг хамруулж цахимаар болон утсаар, ганцаарчилсан зөвлөгөө өгөх арга зүйд сургаж чадавхжуулсан. Үүний үр дүнд сургалтаар бэлтгэгдсэн үе тэнгийн сургагч нар бүлгээр хамтран хүүхэд өсвөр үеийнхэнд бэлгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар өртөөлчилсэн сургалтуудыг зохион байгуулж Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1, 2, 5, 11, 12 дугаар сургууль, “Шинэ хөгжил”, “Хан-Уул” цогцолбор сургуулийн дунд ахлах ангийн 700 гаруй өсвөр насны хүүхдүүдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар охидын бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн чиглэлээр сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах чиг үүрэг бүхий “Аз жаргал төв”-ийг байгуулан ажиллуулж эхлээд байна.	100
35	2.1.6.“Эрүүл цус-5” аян болон эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.	Жилдээ	Бэлгийн замын халдварт өвчний тархалт буурна.	Бэлгийн замаар дамжих халдвар, тэмбүүгээс урьдчилан сэргийлэх “Эрүүл цус-5” аяныг аймгийн Засаг даргын 2017 оны А/38 дугаар захирамж, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А/14 тоот тушаалын дагуу аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байна. Зорилтот бүлгийн 14-55 насны хамрагдвал зохих 12000 иргэдээс 6800 хүн буюу 56,6 хувийг хамруулж, эерэг 622/9,2%/ тохиолдлоос шинэ тэмбүү 184 тохиолдлыг илрүүлж, 153 хүнийг эмчилгээнд оруулж, эдгэрэлт 83,2 хувьтай байна.	70

36	2.1.7.Алслагдсан хөдөөгийн хүн амд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг "Явуулын амбулатори" хэлбэрээр үзүүлнэ.	Жилдээ	Иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Алслагдсан нутагт өвөлжиж, хаваржиж, буй зорилтот бүлгийн иргэдэд төрөлжсөн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг үзүүлэх, гамшгийн үеийн бэлэн байдал, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор "Явуулын амбулатори"-ийн үзлэг 14 сумын 475 өрхийн 1298 иргэний гэрт нь очиж, нийгмийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан. Сумын төвүүдэд үзлэг хийж нийт 4383 хүнд шүд, дотор, хүүхэд сэтгэц, эмэгтэйчүүдийн эмчийн тусламж, үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мөн Хөдөлгөөнт эмнэлэг 9 дүгээр сарын 11-нээс эхлэн 8 суманд ажиллаж, 2471 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлээд байна. Тус үйлчилгээ нь 10 дугаар сарын 26-ныг хүртэл үргэлжилнэ.	70
37	2.1.8.Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг зохион байгуулна.	Жилдээ	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ	Сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг 2016 онд өвчлөл өндөртэй Булган, Матад, Гурванзагал, Чулуунхороот, Чойбалсан сумдад зохион байгуулахаар төлөвлөн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн зөөврийн рентген аппаратыг ажиллуулах хүсэлтийг гаргасан бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 9-нөөс 20-ны хооронд багтаан илрүүлэг үзлэгт сум тус бүрт 200-300 иргэн хамруулахаар төлөвлөн бүртгэл хийж удирдамж боловсруулан ажиллаж байна.	40
38	2.1.9.Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын болзол журмыг хангасан байгууллага, иргэнийг урамшуулна.	4 дүгээр улирал	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага нэмэгдэнэ.	Хэрлэн сумын 1, 2, 6 дугаар цэцэрлэг 2 дугаар зэрэг, 4, 11 дүгээр цэцэрлэг 3 дугаар зэргийн гэрчилгээ авч өмнөх оны мөн үеэс 3 байгууллагаар нэмэгдэж байна. Иргэнийг урамшуулах хугацаа 12 дугаар сард болно.	70
39	2.1.10."Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилдээ	Халдварт бус өвчлөл буурна.	"Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 773 иргэнд цусны даралт хэмжих, биеийн ерөнхий найрлага болон цусан дахь сахар тодорхойлох үзлэгийг хийж, эрүүл мэндийн боловсрол олгож, зөвлөгөө өгч ажилласан. 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 12 байгууллага, 4 багийн 355 иргэнд хорт зуршлын хэрэглээ, түүний хор хөнөөл сэдвээр 1163 иргэнд гарын авлага тараан, сургалт, зөвлөгөө өгсөн. "Архи тамхины эсрэг цэцэг-4" өдөрлөгийг 4 дэх жилдээ тэмдэглэж, хүн амд архи тамхины хор уршиг, түүнээс үүсэх өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хорт зуршлын эсрэг өрөө тасалгааг цэцэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маяг хэвшүүлэх үүднээс ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулж, 100 гаруй цэцгийг иргэдэд түгээж, зарим иргэдтэй цэцэг солилцсон. Өдөрлөгөөр 12 сургуулийн сурагчид "Эрүүл амьдрал-идэвхтэй хөдөлгөөн" дасгал хөдөлгөөнийг сурталчилсан. "Архи тамхины эсрэг цэцэг" болзолт уралдаанд 8 байгууллага, 6 сургууль, 3 цэцэрлэг, 200 гаруй иргэд оролцоноос Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 8 дугаар сургууль, 1 дүгээр цэцэрлэгүүд тус тус шалгарлаа. Мөн талбайн гар зургийн уралдаанд оролцогчид болон архи, тамхинаас татгалзсан 5-10 жилийн эдгэрэлттэй байгаа 6 иргэнийг урамшуулж гарын бэлэг гардуулсан.	70

				Архины хамаарал бүхий 71 иргэнд нийгмийн цогц үйлчилгээг үзүүлэх нэгдсэн арга хэмжээг аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газартай хамтран зохион байгууллаа. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг энэ оны эхний 9 сарын байдлаар 109628 буюу 39 хувьтай байна. Хорт хавдрын нас баралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.	
40	2.1.11.Цус, цусан бүтээгдэхүүний зайлшгүй байх нөөцийг бүрдүүлэх зорилгоор донорын тоог нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаа хийнэ.	2 дугаар улирал	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.	Аймгийн Засаг даргын 2015 оны А/285 дугаар захирамжаар батлагдсан Цусны донорын нөөцийг бүрдүүлэх талаар аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Цусны салбар төв донорын сургалт сурталчилгааны төсөв, төлөвлөгөөг гаргасан бөгөөд жишиг тасаг болсон. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01, 02 дугаар тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилготойгоор жил бүрийн 06 дугаар сарын 14-ны цусаа бэлэглэгч доноруудыг алдаршуулах, талархал илэрхийлэх өдрийг зохион байгууллаа. Аймгийн Улаан загалмайн хорооны 60 жилийн ойг угтан Монгол улсад анх удаа Доноруудад зориулсан хөшөө босголоо. Өмнөх онд 2027 сайн дурын донор байсан бол энэ онд 76 донороор нэмэгдэж, 2103 болж өссөн байна.	100
41	2.1.12.Оюутны эрүүл мэндийг дэмжих ажлыг зохион байгуулна.	1, 2, 4 дүгээр улирал	Иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ	Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны нээлтийн өдөрлөгийг 9 дүгээр сарын 8-ны өдөр Дорнод Политехникийн коллежийн Эко талбайд нээлтийн өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр Дорнод их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт 270 гаруй оюутан залуус оролцож body analyzer-аар биеийн ерөнхий үзүүлэлтийг үзэж, эрүүл зохистой хоолны амталгаа явуулж, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны материалыг түгээсэн. Мөн 300 гаруй оюутан залууст сэтгэл зүйн болон эрүүл, зөв хооллолт, архи, тамхи, түүний хор нөлөө, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржхүйн эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр сургалт явуулж, 4 төрлийн гарын авлага, материалаар хангаад байна. Амны хөндийн эрүүл ахуйн үзлэг, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 330 оюутнуудыг хамруулсан.	70
42	2.1.13.Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран уламжлалт анагаах ухааны чиглэлээр эмч мэргэжилтэн сургах, эрдэм шинжилгээ, судалгааны Олон улсын хурал зохион байгуулна	3 дугаар улирал	Цахим бүртгэлийн нэгдсэн сантай болох цаасгүй эмнэлэг болох анхны алхам тавигдана	Аймгийн Засаг дарга болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын дарга нарын хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичигт уламжлалт анагаах ухааны чиглэлээр жилд 3 удаа, нэг удаа 6 хүртэлх тооны эмч, сувилагчийг хамруулах, жилд нэг удаа уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, монгол эмчилгээний тал дээр хамтран ажиллах, эмт ургамлыг хуулийн хүрээнд хамтран судалгаа хийх, монгол эм үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаар тусгагдаад байна. Энэ оны 10 дугаар сарын 22-ны өдөр Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээний уулзалтыг зохион байгуулна.	70
43	2.1.14.Орон нутгийн иргэдийн эмчилгээнд ашиглагдаж байгаа аймгийн нутаг дэвсгэрт	3,4 дүгээр улирал	Эмийн ургамал, рашаан, булаг шанд хамгаалагдсан байна.	Матад сум “Нарангийн рашаан” хэмээх Бөөр нуруу болон үе мөчний эмчилгээнд ашигладаг рашаантай ба булгийн эхийг хамгаалах, адуу мал	40

	ургадаг байгалийн эмт бодис, рашаан, шаврын ордыг шинжлүүлэх, нөөцийг судлах, паспортжуулан хамгаалах ажлыг үе шаттай зохион байгуулна.			орохоос хамгаалан хашиж, амрагчдын ая тухтай байдлыг ханган сүүдрэвч, тоглоомын талбайг шинээр байгуулсан. Рашаан, шаврын ордыг шинжлүүлэх, нөөцийг судлах, паспортжуулан хамгаалах ажил одоогоор хийгдээгүй байна.	
44	2.1.15.Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх дэд төслийг хэрэгжүүлнэ.	Жилдээ	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй, Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын дунд иргэдэд тэгш, шуурхай, чанартай үйлчлэх хандлага бий болно.	Аймгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог хангах зорилго бүхий “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийг Швейцарийн хөгжлийн агентлаг, Дэлхийн банкттай хамтран санхүүжүүлж орон нутагт энэ оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Швейцарийн хөгжлийн агентлаг, дэлхийн банкны санхүүжилтээр “Эмзэг бүлгийн иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд Хэрлэн сумын 1, 2, 8 дугаар багийн зорилтот бүлгийн иргэдэд аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүд хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Зүрх судас, дотор, мэдрэл, хүүхэд, чих хамар хоолой, шүдний эрүүл ахуйч эмч, өрхийн эмч нар элэгний вирус тодорхойлох шинжилгээ, зүрхний бичлэг хийх зэрэг үйлчилгээг нийт 1454 иргэн үзүүлсэн байна. Мөн төслийн хүрээнд “Таны төлөө” нээлттэй хаалганы өдөрлөгт Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 16 тасаг нэгжийн эмч, сувилагч нар оролцож, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө өгч ажиллав. Үүнд: Цусны сахар тодорхойлох шинжилгээ, цусны даралт хэмжилт, биеийн жингийн индекс тодорхойлох, ерөнхий мэргэжлийн эмчийн үзлэг, эхо, хөдөлгөөн засал, хүчилтөрөгчийн коктейль, захын судасны хүчилтөрөгчийн хангамж тодорхойлох зэрэг үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 2243 иргэн хамрагдаж, эрүүл мэндийн санамж, сургалт сурталчилгааны материалыг түгээн ажилласан.	100
2.2 Боловсрол, соёл урлаг, спортын салбар: Боловсрол, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж хүүхэд, багш болон боловсрол, соёлын ажилтан нэг бүрийн хөгжлийг дэмжинэ.					
45	2.2.1.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ. /Хэрлэн сумын 2, 3, 4 дүгээр баг/	3,4 дүгээр улирал	Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч, хөгжих таатай орчин бүрдэж, сургалтын чанар, хүртээмж нэмэгдэнэ.	Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр багт Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 100 хүүхдийн ортой 15 дугаар цэцэрлэг баригдаж, 2017 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, 145 хүүхдийг хамруулсан. Хэрлэн сумын 4 дүгээр багийн цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 47% нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаад байна. Хэрлэн сумын 3 дугаар багт Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар 6 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн багтаамжтай шинэ барилга барихад дэмжлэг үзүүлэхээр болсон. Одоогийн байдлаар гэрээ хэлцэл хийгдээгүй байна. Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг шинээр байгуулагдаж, 250 хүүхдийг цэцэрлэгт хамруулсан. Мөн Чулуунхороот, Баяндун суманд болон Хэрлэн сумын 7	70

				<p>дугаар цэцэрлэгүүдэд гэр цэцэрлэг байгуулснаар сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт нэмэгдсэн. Одоогоор хувилбарт сургалтад нийт 423 хүүхэд хамрагдаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүүжилтээр нийт 6,0 сая төгрөгийн өртөгтэй 3 гэр олгосон.</p> <p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 82 дугаар “Барилгыг зориулалтын дагуу ашиглах тухай” тогтоолоор Хан-Уул цогцолбор сургуулийн 6 настны бүлгийн хичээлийн байрыг цэцэрлэгийн зориулалтаар ашиглах тухай шийдвэр гарсан. Өнөөдрийн байдлаар хүлээлгэн өгөх, засварлах үйл ажиллагаа хийгдээгүй байна.</p> <p>2017-2018 оны хичээлийн жилд Дорнод аймгийн хэмжээнд төрийн өмчийн 29, хувийн өмчийн 8, нийт 37 цэцэрлэгт 7010 хүүхэд хамрагдаж, өмнөх оны хичээлийн жилд 83% байсан бол одоо хамран сургалт 85% байна.</p>	
46	2.2.2.Зарим шаардлагатай сумын боловсрол, соёл урлагийн байгууллагуудын халаалтын системийг сайжруулна.	Жилдээ	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.	<p>Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын гадна дулааны болон халаалтын системийг засварлах, шинэчлэх ажлууд үе шаттай хийгдэж байна. Хан-Уул цогцолбор сургуулийн гадна дулааны шугамыг нэгдсэн дулаанд холбох 46,3 сая төгрөгийн төсөвтэй ажлыг “Цог МН” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн барилгын халаалтын систем засварлах 30,5 сая төгрөгийн, Халхгол сумын Ялалт багийн сургуулийн халаалтын тогоог засварлах 17,0 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр “Бүжнэр” ХХК шалгаран, засвар бүрэн дуусгаж, комисст хүлээлгэн өгөөд байна.</p> <p>Улсын төсвийн 47,5 сая төгрөгөөр Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн гадна дулааны шугамын засвар, аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын барилгын цахилгаан, сантехникийн засварыг 15,0 сая төгрөгөөр хийсэн.</p> <p>Чойбалсан сумын ерөнхий боловсролын сургуулийн уурын зуухыг шинэчлэх ажлын гүйцэтгэлийн дутуу 55,0 сая төгрөгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.</p> <p>Гурванзагал сумын сургуулийн халаалтын тогоог шинэчлэх 23,3 сая төгрөгийн төсөвтэй ажил бүрэн хийгдэж дууссан.</p> <p>Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага сургуулийн халаалтын тогооны засварт 7,3 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн.</p>	100
47	2.2.3.“Хүүхдийн хөгжил, хүмүүжилд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлье” зорилтот жилийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Жилдээ	Хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр боловсролын үйлчилгээнд эцэг эх, иргэд олон нийтийн идэвх оролцоо нэмэгдэж, хүүхдийн хөгжил, хүмүүжилд ахиц гарна.	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар 2016-2017 оны хичээлийн жилийг “Хүүхдийн хөгжил, хүмүүжилд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлье” зорилтот жил болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд 4 чиглэлээр төлөвлөгөө гарган, “Өсвөрийн цагдаа бүлгэм”, өсвөрийн улаан загалмайн “Тусч” бүлгэм, “Охидын клуб”, “Ногоон дэлхий” зэрэг клубүүд ажиллаж, тус клубуудын үйл ажиллагаанд сургуулийн насны нийт 14543 сурагчийн 70 гаруй хувь нь хамрагдаж байна.</p> <p>Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээнд 9800 гаруй сурагч, 4500 орчим эцэг эхийг хамруулсан. Мөн аймгийн 34 цэцэрлэг, 26 сургуулийн 416 багшийг 5 бүс болгон хамтын хөгжилд зөвлөн</p>	100

				туслах, туршлага солилцох бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулсан. “Багш хөгжлийн төв”-ийг зорилтот жилийн хүрээнд 4-өөр нэмэгдүүлэн ажиллаж байна. “Сургууль, цэцэрлэгийн зөвлөл”-ийг боловсролын хуульд зааснаар шинэчилж, цэцэрлэг, сургууль бүр хөгжлийн төлөвлөгөөндөө хүүхдийн хөгжил, хүмүүжлийн асуудлыг тусган хэрэгжүүлж байна.	
48	2.2.4.Орон нутаг эрэлт хэрэгцээтэй мэргэжилтний судалгааг гарган дотоод гадаадын их, дээд сургуульд элсэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	3, 4 дүгээр улирал	Орон нутаг чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэнэ.	<p>Дорнод аймгийн ажиллах хүчний эрэлтийн судалгааг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран 2016-2017 оны байдлаар гаргасан. Судалгаагаар дараах 10 салбарт нийт 733 мэргэжилтэй ажиллах хүч дутагдалтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөө аж ахуй, - Уул уурхай олборлох үйлдвэр, - Боловсруулах үйлдвэр, - Цахилгаан дулаан, усан хангамж, - Барилга, - Худалдаа, - Тээвэр холбоо, - Зочид буудал, зоогийн газар, - Санхүү, - Үйлчилгээ <p>Дорнод их сургуульд энэ хичээлийн жилд 25 мэргэжлээр 359 оюутан суралцаж байна. Тус сургууль хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж энэ хичээлийн жилд шинээр уул уурхайн ашиглалтын технологи, Цаг уурын инженер, Тусгай хэрэгцээт боловсрол зэрэг 3 ангид элсэлт авч байна. Дорнод аймгаас ОХУ-ын Өвөрбайгалийн Мэргэжлийн боловсролын сургуульд 2016-2017 оны хичээлийн жилд 3 оюутан, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр дээд сургуульд 15 оюутан суралцаж байна. 2016-2017 оны хичээлийн жилд Хөлөнбуйр дээд сургуульд 5 оюутан суралцах хүсэлтээ гарган, материалаа хүргүүлээд байгаа бол ОХУ-ын Мэргэжлийн боловсролын 7 сургуульд элсүүлэх мэргэжлийн ангиуд болон элсэлтийн хуваарь батлагдан ирж, бүртгэлийн зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан ажиллаж байна. 2015-2016 оны хичээлийн жилд Дорнод аймгийн ЕБС-ийг 973 сурагч төгсөн, Элсэлтийн ерөнхий шалгалтын 819 буюу 84,2 % орж, Монголын их, дээд сургуулиудын консорциумын гишүүн дотоодын их дээд сургуульд 361 оюутан элсэн суралцсан, /Монгол улсын их сургууль, Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Хууль сахиулахын их сургууль зэрэг онлайн элсэлт ороогүй, мөн албан бус элсэлт ороогүй/ 2016-2017 онд 925 сурагч төгсч Элсэлтийн ерөнхий шалгалтад 843 буюу 91,1% нь оролцсон.</p>	100
49	2.2.5.Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллага бүр өрсөлдөх чадвараа	Жилдээ	Боловсрол, соёлын байгууллагууд хөгжлийн бодлогоо	Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг аймгийн 34 цэцэрлэгээс 33 цэцэрлэг боловсруулсан. Аймгийн 26 сургуулиас 15 сургууль нь хөгжлийн бодлого хөтөлбөрөө 4-5 жилээр төлөвлөн боловсруулсан.	100

	нэмэгдүүлэх хөгжлийн бодлого, хөтөлбөртэй болно.		тодорхойлж, үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэнэ.	Хөтөлбөрт алсын хараа, зорилго, зорилт, хамрах хүрээг тодорхойлон 2020 он хүртэл сургуулийн үйл ажиллагаандаа чиглэл болгон ажиллах хууль эрх зүй, сургуулийн үндсэн үйл ажиллагааны зарчим, хүрэх үр дүн, оюун санааны ба материаллаг хэрэгцээ, нөөц бололцоог ашиглах, хангах, түүнд тавигдах шаардлага, хяналт шалгалт, амжилтын арга замаа хэрхэн сайжруулах талаар тусгасан. Сумдын соёл, урлагийг хөгжүүлэх 4-5 жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний хүрээнд сумдын соёлын төвийн ажилчдын сургалтыг зохион байгууллаа. Сумын соёлын төвүүд бодлого хөтөлбөртэй болсноор үйл ажиллагаа тогтмолжиж, төлөвлөлт чанаржиж, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн үйл ажиллагааны төрөл, чанарт ахиц гарч байна. Мөн соёлын өвийн хадгалалт хамгаалалт, орон нутаг судлах танхим, нийтийн номын сангийн үйл ажиллагаа сайжирсан.	
50	2.2.6.Боловсрол, соёлын салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.	Жилдээ	Боловсрол, соёлын салбарын ажилчдын мэдлэг ур чадвар дээшилнэ.	2017 оны 2 дугаар сард салбарын удирдах ажилтнуудыг чадваржуулах сургалтад 50 удирдах ажилтан, “Уран зохиолын агуулга, арга зүйн шинэчлэл” сургалтад 38 багш, 2, 4 дүгээр сард АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны онлайн сургалтад 20 англи хэлний багш, цэцэрлэгийн арга зүйч, шилдэг багш нар, Заах аргын нэгдлийн туршлага солилцох сургалтад 41 алба хаагч, 1-5 дугаар сард судлагдахууны багш нарыг мэргэжил арга зүйд чадваржуулах зорилгоор Заах аргын нэгдсэн ажлыг аймгийн төвийн бүх сургуулиудад зохион байгуулсан. Бага боловсрол, сургуулийн өмнөх боловсролын судлагдахуун тус бүрээр 4-5 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн 1560 багш, Заах аргын нэгдэл хамрагдсан. 2017 оны 3 дугаар сард аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, аймгийн Аудитын газраас Боловсрол соёл, урлаг, спортын байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зориулсан “Төсөв санхүүтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь” сэдэвт сургалтад 144 албан хаагч оролцсон. Мөн 4 дүгээр сард Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгээр сумдын соёлын төвийн ажилтнуудын мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалт, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар хүний хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх сургалтад дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн бүхий 3 хүн АНУ болон Япон улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.	100
51	2.2.7.Алслагдсан хөдөөгийн хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүргэх ажлыг сумдын удирдлагуудтай хамтран зохион байгуулж, хүүхэд багачуудад зориулсан	3, 4 дүгээр улирал	Хүн амд хүрэх соёл урлагийн арга хэмжээ нэмэгдсэн байна.	Хөгжимт драмын театрын “Театр-хүний хөгжилд” зорилтот жилийн хүрээнд “Classical music” VIP тусгай тоглолтыг 2017 оны 5 дугаар сард зохион байгуулж Хөлөнбуйр сумын 120 иргэн, Булган сумын 60 иргэнд үзүүлж үйлчилсэн. Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг тохиолдуулан Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан, найруулагч Б.Мөнх-Амьдралын зохиол, найруулгаар “Ярьдаг мод” сэдэвт	100

	хүүхдийн жүжиг, уран бүтээлд дэмжлэг үзүүлнэ.			байгаль, эх дэлхийгээ хайрлах үзлийг төлөвшүүлэх хүүхдийн дуулалт жүжгийг аймгийн Хөгжимт драмын театрын тайзнаа 10 удаа тоглож, 4800 гаруй хүүхэд үзэж сонирхсон.	
52	2.2.8. Үзэмчин түмний “Алтан дөрөө” наадмыг зохион байгуулна.	Жилдээ	Хүн амд хүрэх соёл урлагийн арга хэмжээ нэмэгдсэн байна.	Үзэмчин түмний урлаг, спортын “Алтан дөрөө-2017” наадмыг аймгийн Засаг даргын 2017 оны А/170 дугаар захирамжийн дагуу 2017 оны 7 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Баянтүмэн суманд зохион байгуулагдав. Наадамд Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Булган, Хэрлэн сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Улаанбаатар хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны төлөөлөл 1000 гаруй иргэд оролцож спорт, урлагийн арга хэмжээг зохион байгуулснаар залуу хойч үедээ уламжлал зан үйл, ахмадаа хүндлэх ёс заншлыг сурталчлах, өвлөн үлдээх сургамжтай наадам боллоо.	100
53	2.2.9. “Болор цом” яруу найргийн улсын наадмыг зохион байгуулна.	1 дүгээр улиралд	Хүн амд хүрэх соёл урлагийн арга хэмжээ нэмэгдсэн байна.	Монголын зохиолчдын эвлэлээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг яруу найргийн “Болор цом-34” улсын наадмыг 2017 оны 1 дүгээр сард аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг Дорнын их яруу найрагч Данзангийн Нямсүрэн агсны мэндэлсний 70 насны ойн хүрээнд Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулагдсан. Наадмын ерөнхий зохион байгуулагчаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Зохиолчдын Эвлэл, ивээн тэтгэгч байгууллагаар Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, Дорнод аймгийн Морин спорт, уяачдын холбоо, “Дорнод гурил” ХК, “Адуун чулуун” ХК, “TV6”, “Мижиг”, “Шинэ суваг”, “Дорнод”, “PBS” телевиз зэрэг байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ажиллалаа. Наадмын хүрээнд Төрийн 3 удаагийн шагналт, Ардын уран зохиолч, академич, зууны манлай Соён гэгээрүүлэгч Ц.Дамдинсүрэнгийн хөшөөнд цэцэг өргөх ёслол, “Яруу найрагч-Уншигчдын уулзалт”, шинэ номын нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.	100
54	2.2.10. “Номтой нөхөрлөө” дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	Жилдээ	Иргэдийн мэдлэг чадвар нэмэгдсэн байна.	Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Номтой нөхөрлөө” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Номоо солилцож унших өдөр”, “Дэлхийн номын баярын өдөр”-ийг 4 дүгээр сард зохион байгуулсан. Дорнод аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын номын ойн үзэсгэлэн, “Аз хур” номын худалдаа болон Г.Акимын орчуулга А.Гриний “Аранзал дарвуулт хөлөг” зохиолын хэлэлцүүлгийг их дээд сургуулийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Сумдын нийтийн номын сангууд дэд хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээний орчныг сайжруулах тохижилтын ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал: Баян-Уул сумын нийтийн номын сан “Ном бол оюуны талх” 2,0 сая төгрөгийн ном худалдан авах төсөл бичиж, шаардлагатай байгаа номын жагсаалтыг гарган, Улаанбаатар хот, Чойбалсан хот дахь Нутгийн зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлсэн. Мөн Халхгол сумын Соёлын төвийн нийтийн номын сан 14,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Чойбалсан сумын Соёлын төв ном уншлагын танхимыг шинээр тохижуулж “Оюунлаг байгууллага”, “Хүн бүр уншигч” аян зарлаж, иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэхэд анхааран ажиллаж байна.	100

				<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас аймгийн Төв номын санд 3,0 сая төгрөг, сумдын нийтийн номын санд 1,0 сая төгрөгийн фонд баяжилтыг хийлээ. Нийт 13,0 сая төгрөгийн ном худалдан авч, сумдад хүргүүлэн, шинэ номоор уншигчдад үйлчилж байна.</p> <p>Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн дунд “Сэтгэхүйн хурд” тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>2017 оны 9 дүгээр сарын 15-нд Номын баярын өдрийг Тусгаар тогтнолын талбайд тэмдэглэж аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 100 гаруй уншигч-хүүхдүүд оролцсон.</p>	
55	2.2.11.Тамирчдыг олон улс, тив, дэлхийн болон улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.	Жилдээ	Улс, бүсийн чанартай тэмцээнүүдийг аймаг, орон нутагтаа зохион байгуулж, Олон улс, тив, дэлхийн, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд аймгаа төлөөлж оролцсон байна.	<p>Дорнод аймгаас олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах 49 баялагчид 838 алт, 105 мөнгө, 102 хүрэл, 296 хүртсэн байна.</p> <p>Дорнод аймгийн Засаг даргын 2017 оны А/63 дугаар захирамжаар 2017 онд бүс, улс, олон улсад зохион байгуулагдах спортын уралдаан тэмцээний зардалд нийт 65,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төсөвлөснөөс энэ оны 9 сарын байдлаар 58,0 сая төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>Мөн Хүний хөгжил сангаас олон улс, тив, дэлхийн болон улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд дэмжлэг үзүүлж 23,7 сая төгрөгийг зарцуулаад байна.</p>	70
56	2.2.12.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдээс биеийн ерөнхий хөгжлийн сорил авах ажлыг зохион байгуулна.	2 дугаар улирал	Иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийн мэдлэг төлөвшсөн байна.	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар Зарлигийн хүрээнд “Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшинг тогтоох сорил”-ын сарын аяныг 2017 оны 4 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 01-ний хооронд улсын хэмжээнд зарласан. Тус аянд орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулахаар аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, 2058 иргэнийг хамруулж, зарим төрийн болон хувийн хэвшлийн ажилчид, албан хаагчдад эрүүл зан төлвийн талаар мэдээлэл сурталчилгаа хийж, дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийн ач тусыг ойлгуулсан. Төрийн байгууллагын 854 ажилтан, ахмад настан 67, хүүхэд залуучууд 1089, хувиараа хөдөлмөр эрхлэгч 38 иргэн хамрагдаж, нийлбэр дүнгээр С үнэлгээ авсан байна.</p>	100
57	2.2.13.Биеийн тамир спортын байгууллагын гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан бэлтгэл сургуулилтыг зохион байгуулна.	Жилдээ	Тамирчдын ур чадвар нэмэгдсэн байна.	<p>ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Биеийн тамир, спортын сайд тэргүүтэй төлөөлөгчид Биеийн тамир, спортын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Дорнод аймагт айлчилж, хамтарсан бэлтгэл, тэмцээн зохион байгуулах санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>Аймгийн аварга шалгаруулах таэквандо, ширээний теннисний тэмцээнүүдийг нээлттэй зохион байгуулснаар Улаанбаатар хот, БНХАУ, ОХУ-ын баг тамирчид ирж оролцож, манай аймагтай харилцан туршлага судаллаа. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны баг тамирчидтай Дорнод аймгийн бокс болон жүдо бөхийн шигшээ багийн тамирчид хамтарсан бэлтгэл сургуулилт хийсэн.</p> <p>БНСУ-ын “KOICA” олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүсэлт явуулсны үр дүнд тус байгууллагаас Дорнод аймагт таэквандогийн спортын төрлөөр сайн дурын дасгалжуулагч багшийг ажиллуулахаар болсон.</p>	70

				Дорнод аймгийн бадминтоны өсвөрийн 6 тамирчин, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн бадминтоны холбоо хамтарсан бэлтгэл хийж, 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд Рашаан хотод болсон Олон улсын тэмцээнд оролцлоо. Мөн боксын 1 тамирчин, 1 дасгалжуулагч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотод хамтарсан бэлтгэлд хамрагдаж, халз тулаан зохион байгуулсан бөгөөд ирэх 10 дугаар сард Мэргэжлийн боксын тулааныг БНХАУ-д зохион байгуулахаар төлөвлөөд байна.	
2.3 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, иргэний нийгмийн түншлэлийг нэмэгдүүлэх салбарын хүрээнд:					
58	2.3.1. “Хүүхдэд ээлтэй засаглал 2020” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	Жилдээ	Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллыг дэмжсэн шинэ нэр төрлийн үйлчилгээг нэмэгдүүлсэн байна.	“Хүүхдэд ээлтэй засаглал-2020 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн төсвөөс нийт 139,0 сая төгрөгийг батлуулсан. Үүнээс Хүүхэд хөгжил төв 2, Залуу техникч клуб, Охидын соёл хөгжлийн Аз жаргал төв, Тэжээлийн доройтолтой болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийг эмчлэн сувилах, хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн олон талт үйл ажиллагаанд зарцуулан үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох, өсвөр үеийнхний авьяас чадвар, давуу тал, ололт амжилт, үлгэр дуурайлал, оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор 8 нэр төрлийн үйл ажиллагаанд 10,0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс баталсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар 80%-ийн гүйцэтгэлтэй байна. Үр дүн: Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн тогтвортой үйл ажиллагаа явуулах 4 төвийг шинээр байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаанд 7257 хүүхэд, 2500 орчим эцэг эхийг хамруулсан.	70
59	2.3.2.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж, бүтээлч, хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна.	Жилдээ	Залуучуудын идэвх санаачилга нэмэгдэж хандлагад өөрчлөлт орсон байна.	2017 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, зорилтот жилийн хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/33 тоот захирамжаар сар бүрийн 11-ний өдрийг “Залуучуудаа сонсох өдөр” болгон зарлаж, нийт 7 удаагийн уулзалтаар 230 гаруй залуучуудын санал бодлыг сонслоо. Уулзалтаас нийт 50 гаруй санал гарсан бөгөөд хуулийн хүрээнд шийдвэрлэж болох асуудлуудыг эрэмбэлэн 60 гаруй хувийг шийдвэрлээд байна. Тухайлбал “Дорнод залуус” мэдээллийн нэгдсэн сайт, аппликейшнийг нийт 10.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэн ашиглалтад оруулсан. Мөн Аймгийн ИТХ-ын 04 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолоор “Дорнод аймгийн Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулан орон нутгийн төсвөөс нийт 34.0 сая төгрөгийг батлуулсан. Үр дүн: Энэ онд 13 томоохон үйл ажиллагаа төлөвлөснөөс эхний 10 сарын байдлаар нийт 11 удаагийн томоохон арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 6000 гаруй залуучууд, иргэдэд хүрч ажилласан.	70
2.4 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд:					
60	2.4.1. “Ахмадаа ачлах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн	Жилдээ 10 сая	Ахмадын нийгмийн хамгааллын	Дорнод аймаг анх 2015 онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулах ажлыг эхлүүлсэн. Тус	70

	хэрэгжүүлж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ.		үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	онд 2 чиглэлд 96,0 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бол жил бүр санхүүжилтийг нэмэгдүүлж, 2017 онд 2 автобусыг нэмж, орон нутгийн төсөвт 160,0 сая төгрөгийн эх үүсвэрийг батлуулж, бүх багуудад ахмад настны нийтийн тээврийн үйлчилгээг үнэ төлбөргүй явуулж эхэлсэн. - Аймгийн Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу "Ахмадын зөвлөх баг" ажиллуулах удирдамж боловсруулан батлуулж, зөвлөх үйлчилгээнд 40 гаруй ахмадыг хамруулан ахмадын судалгааг авч байна. - Аймгийн Засаг даргын ивээл дор уламжлал болон зохион байгуулагддаг ахмадын урлаг спортын 6-р наадмыг 2017 оны 09 дүгээр сарын 6-8-ны хооронд зохион байгууллаа. Тус наадамд 14 сумын 182 ахмад урлаг, спортын 11 төрлөөр оролцлоо. Мөн наадмыг угтан аймгийн Ахмадын хорооноос санаачлан 2017 оны 09 дүгээр сарын 6-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд ахмадууд өөрсдийн гараар тарьж ургуулсан хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, нийт 12,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үр дүн: Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөл байгуулагдан 8 үйл ажиллагааг төлөвлөснөөс гүйцэтгэл 80 хувьтай бөгөөд энэ сард "Эх орон танаа" сэдэвт залуу үе, ахмад настны залгамж холбоог сайжруулах чуулга уулзалт 11 дүгээр сарын 20-ны өдөр болно. Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх нийтийн тээврээр давхардсан тоогоор 12 мянга гаруй иргэд үйлчлүүлсэн байна.	
61	2.4.2."Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилдээ 10 сая	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоог дэмжсэн үйл ажиллагаа нэмэгдэнэ.	Аймгийн Засаг даргын захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Эхний 10 сарын байдлаар "Зорилготой амьдрал" сургалтын төв нь Хэрлэн сумын 1, 6, 7, 10 дугаар багуудын зорилтот бүлгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдэд 4 төрлийн сургалт, хэрэгцээ тодорхойлох судалгаанд хамруулах, "Эмэгтэйчүүдийн эрх, жендерт суурилсан хүчирхийлэл" сэдэвт сургалт, мэдээллийг зохион байгуулан нийт 540 гаруй охид эмэгтэйчүүдийг хамруулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд "Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" Дорнод аймгийн эмэгтэйчүүдийн 5 дугаар чуулга уулзалтыг зохион байгуулан 500 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд сонгогдсон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч 38 эмэгтэйд Дорнод аймгийн Эмэгтэйчүүдийн сүлжээ байгууллагууд манлайллын талаар уулзалт ярилцлага зохион байгуулсан. Үр дүн: Нийгэм дэх эмэгтэйчүүдийн манлайлал, үүрэг оролцоо дээшилсэн. Тус хөтөлбөрийн үр дүнд иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан.	100
62	2.4.3."Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлнэ.	Жилдээ 10 сая	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын	Аймгийн Засаг даргын 2017 оны А/300 тоот захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 10,0 сая төгрөгийг батлуулан үйл ажиллагаа төлөвлөгөөг холбогдох байгууллага, хороодод хүргүүлэн ажиллаж байна. Одоогоор 2 шатны пара тэмцээн уралдаанд тамирчдыг оролцуулах,	70

63	2.4.4.Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгааны үр дүнд суурилсан зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэнэ.	Жилдээ	Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт хүрсэн байна.	Монгол улсын Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоол, Монгол улсын Засгийн газрын хуралдааны 2016 оны 58 дугаар тэмдэглэлд даалгаснаар орлогыг орлуулан тооцох аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа улсын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал 15 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд 15846 өрх буюу хамрагдвал зохих өрхийн 99,3 хувь нь хамрагдлаа. Энэ судалгааны үр дүнд Азийн хөгжлийн банк түвшин тогтоох үнэлгээ хийснээр өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох бөгөөд зорилтот бүлгийг тогтооно. Дээрх шинэчилсэн аргачлалаар хийгдсэн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа нь шалгуур үзүүлэлтээ сайжруулж, бодит амьдралд нийцүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Хүн амын мэдээллийн сангийн программ, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын мэдээлэлтэй өрх, иргэний өгсөн мэдээллийг тулгаж, зөв мэдээллийг үндэслэн өрхийн оноо бодогддог байх зохицуулалт хийгдсэн ба иргэдийн өгсөн мэдээллийг бусад салбартай тулгаж дахин баталгаажуулалт хийж, дүнг нэгтэх юм.	70
64	2.4.5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Жилдээ	Хуулийн хэрэгжилтийг ханган, иргэдэд хүрэх жендерийн талаарх мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ.	Монгол улсад “Гэр бүлийн тухай” хууль, “Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдан гарсантай холбогдуулан “Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийн хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагын нийт 70 гаруй иргэд оролцлоо. Хүүхэд хамгааллын чиглэлээр “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх дэлхийн өдөр”, “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ” чуулган, “Эрсдэлтэй гэр бүлтэй ажиллах хамтарсан багийн зөвлөгөөн”, “Хүүхэд, гэр бүлд хүргэх сэтгэл зүйн үйлчилгээ”, “Гэрлэлт ба үүрэг хариуцлага”, “Хүүхдийн эрх хамгаалал, хууль эрх зүйн шинэчлэл” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зэрэг 40 гаруй удаагийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Үр дүн: Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороог шинэчлэн байгуулж, жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагаанд давхардсан тоогоор 5445 иргэнийг хамрууллаа. Эмэгтэйчүүдийн хөтөлбөрийн үр дүнд суурилан жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор суурь судалгаа хийлгэх ажлыг эхлүүлээд байна.	100
2.5. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шилжилт хөдөлгөөнийг бууруулах суурь нөхцөлийг бий болгох ажлын хүрээнд:					
65	2.5.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөтөлбөр, төсөл арга	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,	Оны эхний 9 сарын байдлаар 807 ажлын шинэ байрыг LMIS сайтад бүртгэж мэдээлээд байна. Эдгээр ажлын шинэ байрыг эдийн засгийн үйл ажиллагааны	100

	хэмжээг хэрэгжүүлэх замаар 800-аас доошгүй түр болон байнгын ажлын байрыг шинээр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.		төсөл арга хэмжээг хэрэгжүүлж шинээр бий болсон 800-аас доошгүй ажлын байрны мэдээллийг LMIS сайтад бүртгэж, мэдээлсэн байна.	салбараар ангилбал, бөөний болон жижиглэн худалдаа, машин механизмын засвар үйлчилгээ 342, уул уурхай 289, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 70, боловсрол 28, боловсруулах үйлдвэрлэл 35, барилга 6, усан хангамж 5, боловсрол 31, эрүүл мэнд, мэдээлэл холбоо, даатгалын үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах, үйлчилгээний чиглэлээр тус бүр 1, нийт 807 иргэн ажиллаж байна.	
66	2.5.2.Иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, ажил олгогчийн захиалгын дагуу 1200-оос доошгүй иргэдийг ажилд зуучилна.	Жилдээ	Иргэд ажлын байраар хангагдаж ажилгүйдлийн түвшин буурсан байна.	Аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар албан даалгаврын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудаас сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг шаардлагын дагуу хүлээн авч, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайгч иргэдэд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллийн самбар, вэб сайт, байгууллагын албан хуудас болон утсаар мэдээлэл хүргэн ажиллаж байна. Ингэснээр гуравдугаар улирлын байдлаар 944 иргэнийг ажилд зуучлаад байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,1 хувиар өссөн байна. Мөн зуучлагдсан иргэдийг Зүүн бүсийн аймгуудтай харьцуулахад Сүхбаатар аймгаас 1,8 хувь, Хэнтий аймгаас 2,8 хувиар илүү бөгөөд бүсийн нийт зуучлагдсан иргэдийн 1,3 хувь, улсын нийт зуучлагдсан иргэдийн 1,9 хувийг тус тус эзэлж байна.	70
67	2.5.3.Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хорооны ажлыг эрчимжүүлж, хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн өөрчлөлтийг сурталчилж хэрэгжилтийг хангуулна.	Жилдээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар иргэд, аж ахуйн нэгж байгууллага мэдээлэлтэй болсон байна.	Аймгийн Засаг даргын 2017 оны А/62 дугаар захирамжаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг байгуулж ажиллах талаар чиглэл өгч ажилласнаар 13 суманд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сумын зөвлөл байгуулагдаад байна. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг уламжлалын дагуу зохион байгуулж, сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон аж ахуйн нэгж, байгууллагад сарын аяныг зохион байгуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажиллалаа. Энэхүү сарын аяны хүрээнд хөдөлмөр, хамгааллын ажилтны сургалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөрийн хэлэлцүүлэг, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад түгээн дэлгэрүүлэх” сургалт, туршлага солилцох уулзалт, тэмцээн зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Эдгээр арга хэмжээнд давхардсан тоогоор 46 байгууллагын 500-аад иргэн хамрагдсан. Мөн “Хөдөлмөр эрхлэлт-2017”, “Халамж хүртэгчээс-хөдөлмөр эрхлэгчид” хөтөлбөрийн нээлт, “Хууль сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр “Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажлын байрандаа мөрдөгчөө” хөтөч цүнхийг сурталчилж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлууд болон хөдөлмөр эрхлэлтийг	70

				дэмжих сангаас олгож буй жижиг зээлийн мэдээлэл зэргийг нийт 119 иргэнд хүргэж ажиллалаа.	
68	2.5.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчийн хамтын ажиллагааг өргөжүүлж, орон нутагтаа мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажлын байраар хангах бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөтөлбөр төсөл арга хэмжээтэй уялдуулах замаар шийдвэрлэнэ.	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр хэрэгжиж мэргэжилтэй ажилтан ажлын байраар хангагдсан байна.	Тус аймгийн залуучууд болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-тэй уялдуулан хамруулах зорилгоор эргэн төлөгдөх санхүүгийн төслийг нээлттэй зарласнаар 24 бүлгийн 36 төгсөгчийн төслийг хүлээн авснаас 16 бүлгийн 32 төгсөгчийг сонгон шалгаруулж, 64,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, 32 ажлын шинэ байрыг бий болгоод байна. 2016-2017 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг 395 суралцагч төгссөнөөс одоогоор 120 төгсөгч ажлын байраар хангагдаад байна.	100
69	2.5.5.Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдэд жижиг зээл олгох, бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлэх, аж ахуй эрхлэлтийн мэдлэг эзэмшүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, албан хэлбэрт шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.	Жилдээ	Хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдэд банкаар дамжуулан жижиг зээл олгох замаар ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн төслийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласнаар хүнс, хөнгөн үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, мод, модон эдлэл болон өрхийн үйлдвэрлэл, зөгийн аж ахуй зэрэг чиглэлээр нийт 138 төсөл ирүүлснээс 68 иргэнд 194,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоод байна. Мөн зорилтот бүлгийн 5 иргэнийг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдээс “Жараахайн булаг” ХХК-д ажил олгогчийг дэмжих 4,6 сая төгрөгийн урамшууллыг олгоод байна. Бүлгийн зохион байгуулалттай, ногоо тарих чиглэлээр 14 сумын 27 бүлгийн 82 иргэнтэй гэрээ байгуулж, 38,9 сая төгрөгийг олгосноор аймгийн хэмжээнд 16 га газарт төмс, хүнсний ногоо тариалаад байна. Нийтийг хамарсан түр ажлын байраар 7 сумын 201 иргэнийг хамруулж, 38,4 сая төгрөг зарцуулаад байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журмын дагуу малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, аж ахуйн нэгжид олгохоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газар, Голомт банктай байгуулсан гэрээний дагуу 650,0 сая төгрөгийг байршуулж, 51 иргэний өргөдөл, төслийн танилцуулга ирснээс 14 аж ахуйн нэгж, иргэний зээлийг шалгуур үзүүлэлтийн дагуу судлан тодорхойлолтыг хүргүүлж, 37 ажлын шинэ байрыг бий болгоод байна.	100
70	2.5.6.Орлого багатай болон хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг ажлын байр, түрээсийн хөнгөлөлт болон орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд давуу эрхтэйгээр нийлүүлэх,	Жилдээ	Хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйл ажиллагаа сайжирч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг ажлын байр, түрээсийн хөнгөлөлтөөр	Хувиараа болон бусадтай хамтран аж ахуй, бичил бизнес эрхлэгч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах, орлогыг дэмжих зорилгоор Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, “Дорнод худалдаа” ХХК-ийн “Шүр зах”, “ЕХРО” худалдааны төвд борлуулалтын цэг ажиллуулах санал хүргүүлснээр 4 иргэний 12 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг борлуулж, 762,0 мянган төгрөгийн орлого олсон байна. Өнгөрсөн онд ажилгүй иргэд, залуучуудад хөдөлмөрлөх, орлогоо нэмэгдүүлэх, бүлгээр болон хувиараа аж ахуй эрхлэх арга, мэдлэг эзэмшүүлэх “Зуны	100

	бодлогоор дэмжих, залуучуудад чиглэсэн хөдөлмөрийн дадлага, мэдлэг олгох төв байгуулах, ажиллуулах санаачилгыг дэмжинэ.		дэмжиж Хөдөлмөр сургалтын зуны дадлагын төвийн үйл ажиллагаа тогтворжино.	хөдөлмөрийн сургалт, дадлагын төв"-ийг Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт шинээр байгуулсан. Энэхүү төвд одоогоор өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, ногоо тарих хүсэлтэй Хэрлэн сумын 7 бүлгийн 23 иргэн 3 га газарт төмс, хүнсний ногоо тариалж, одоогоор 2,1 тн нарийн ногоо хураагаад байна.	
71	2.5.7.Хөдөлмөрийн харилцааг бүх шатанд оновчтой, зөв удирдлага, зохион байгуулалтаар хангах үүднээс төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжин ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг баталж мөрдүүлнэ.	Жилдээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр хэрэгжиж эхэлнэ.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний 5 дахь хөтөлбөрийн төсөлд санал авах нээлттэй хэлэлцүүлгийг 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж ажилласан. Хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Политехникийн коллеж, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Үндэсний холбооны аймгийн зөвлөл зэрэг байгууллагын 13 төлөөлөл оролцсон ба хэлэлцүүлгээс гарсан саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний 5 дахь хөтөлбөр Монгол улсын Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан. Түүнтэй уялдуулан аймгийн дэд хөтөлбөрийн төслийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн зөвлөлөөр хэлэлцэн, гишүүдийн саналыг тусган боловсруулж, төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлнэ.	40
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД.					
3.1. Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлнэ.					
72	3.1.1.Малын тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримталж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхтай малын тоог нэмэгдүүлнэ.	Жилдээ	Сүргийн бүтцийг зохистой харьцааг Монгол мал үндэсний хөтөлбөрийн зорилтот түвшинд хүргэнэ .	Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 14 сумын 4398 малчин өрхөд 1722910 толгой мал тоологдсон бол 2017-2018 онд аймгийн хэмжээнд 2,2 сая толгой мал өвөлжинө. 2017 онд тэмээний тоог нэмэгдүүлэх зорилгоор "Тэмээ" дэд хөтөлбөр, хонины тоог нэмэгдүүлэх чиглэлээр нутгийн шилмэл омог, үүлдрийн /Барга, Үзэмчин/ малын хээлтүүлэгч, хээлтэгчид ангилалт хийж, тусгай суурь болгон сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлан үржүүлж байна. Шилмэл үүлдэр, омгийн сүрэг өмнөх онтой харьцуулахад Үзэмчин үүлдэрийн хонь 4959 толгой буюу 15,7 хувиар, Барга үүлдэрийн хонь 5776 толгой буюу 7,8 хувиар, Буриад омгийн хонь 3513 толгой буюу 4,6 хувиар тус тус өссөн байна.	100
73	3.1.2.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдсэн байна.	Тайлант хугацаанд инженерийн хийцтэй гүн өрмийн 14 худаг шинээр гаргаж, бэлчээрийн усан хангаж өмнөх оныхоос 1,8 хувиар нэмэгдсэн. Үүнд: Орон нутгийн төсвийн 60,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хөлөнбуйр, Гурванзагал, Баян-Уул, Баяндун сумдад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 55,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн сумын 5 дугаар баг, Булган сум, Матад, Халхгол сумдад нийт инженерийн хийцтэй гүн өрмийн 8 худгийг тендерт шалгарсан "САТАБУ" ХХК-тай гэрээ байгуулан гаргуулж, ажлын хэсэг хүлээж авсан.	100

				Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгосон худгийн өрөмдлөгийн машины иж бүрдлийн үнийн эргэн төлөлтөд “Дөлгөөн Хэрлэн” ХХК-тай 7 худаг гаргуулахаар гэрээ байгуулж, өнөөдрийн байдлаар Чойбалсан суманд 3, Баян-Уул, Баяндун, Цагаан-Овоо суманд тус бүр 1, нийт 6 худгийг гаргаад байна.	
74	3.1.3.Мал аж ахуйн салбарын боловсон хүчинг давтан сургах, сургалт зөвлөгөөнийг үе шаттайгаар зохион байгуулна.	Жилдээ	Мал аж ахуйн салбарт сургалт зөвлөгөөнүүдийг зохион байгуулж боловсон хүчний чадавх нэмэгдэнэ.	“Бог малын ангилагч-шинжээч мэргэжилтэн” бэлтгэх сургалтанд 2 сумын 2 мэргэжилтэн, “Гангаас улбаатай зудын хүндрэлийг эрсдэл багатай даван туулахад яаралтай тусламж үзүүлэх, чадавхийг сайжруулах” сургалтыг 14 сумын мэргэжилтнүүдэд, “Хөгжиж буй орнуудад биохимийн менежментийг дэмжих семинар-2017”-д 1 мэргэжилтэн, Олон нийттэй харилцах ажилтнуудад зориулсан “Иргэдийн оролцоог хангахад олон нийтийн сүлжээг ашиглах нь” сургалтанд 1 мэргэжилтэн, нийт 18 мэргэжилтэнг сургалтанд хамруулсан. Малыг гоц халдварт өвчин гарсан үед ажиллах практик сургалтад 19, албан хаагч, сумдын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн 7 мэргэжилтэн хамрагдсан. Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд 3 удаагийн сургалтад мал аж ахуйн салбарын 20 гаруй мэргэжилтнийг хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэв.	100
75	3.1.4.Мал амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, халдваргүйжүүлэх, дархлаажуулах ажлыг эрчимжүүлнэ.	Жилдээ	Малын халдварт өвчний гаралт тархалт буурсан байна.	2017 онд орон нутгийн халдварт 12 нэр төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 782,1 мянган толгой мал хамруулахаас 585.0 мянган толгой малыг хамруулж, 74,8 хувийн гүйцэтгэлтэй, өвчний халдварлалт 1,4 хувиар буурсан дүнтэй байна. Аймгийн Засаг даргын 2017 оны А/171 дугаар захирамжийн дагуу хонины гоц халдварт А-040 өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Халхгол, Матад, Хөлөнбуйр, Булган, Баянтүмэн, Хэрлэн сумын 267699 толгой бог малыг хамруулахаас 248957 толгой бог мал хамруулж 93,0 хувийн гүйцэтгэлтэй хийж, 2017 онд гоц халдварт цэцэг өвчин гаргаагүй. Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн Засаг даргын 2017 оны А/318 дугаар захирамжийн хүрээнд угааврын арга хэмжээнд нийт 456,6 мянган толгой мал сүргийг хамруулахаас 353,5 мянган толгой мал сүргийг хамруулан гүйцэтгэл 74,4 хувьтай явагдаж, халдварлалт өнгөрсөн оныхоос 61,3 хувиар буурсан үзүүлэлтэй. Зооноз бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх Аймгийн Засаг даргын 2017 оны А/396 дугаар захирамжийн хүрээнд бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 454,4 мянган толгой төл мал /тугал-27874, хурга-267876, ишиг-157120/ хамруулахаас 441.5 мянган толгойг хамруулж, 96,7 хувийн гүйцэтгэлтэй, халдварлалт өнгөрсөн оныхоос 1,3 хувиар буурсан үзүүлэлтэй. Малыг гоц халдварт шүлхий өвчний голомттой Булган, Баян-Уул, Хөлөнбуйр, Матад, Цагаан-Овоо сумдын 57,9 мянган толгой үхэр сүргийг 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн вакцинд хамруулахаас 25,1 мянган толгой үхэр сүргийг хамруулж, вакцинжуулалт 40 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70

76	3.1.5.Нийт бэлчээрийн 16-аас доошгүй хувийг сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгох асуудлыг шийдвэрлүүлэх, бэлчээрийн төлөв байдал, доройтлын үнэлгээг олон улсын аргачлалаар Цагаан-Овоо, Булган, Баян-Уул суманд хийнэ.	Жилдээ	Хууль тогтоомжийн дагуу сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгох бэлчээрийн талбайн хэмжээг зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Газрын тухай хуулийн 20.1.2-т заасны дагуу нөөц бэлчээрийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, хилийн цэгийг тогтоож, ашиглалтын журмыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах үлгэрчилсэн зааврыг хүргүүлсний дагуу Чулуунхороот, Гурванзагал, Матад, Халхгол, Цагаан-Овоо, Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 1,4 сая га буюу нийт бэлчээрийн газрын 17,5 хувийг орон нутгийн тусгай хэрэгцээнд нөөц бэлчээрийн зориулалтаар авч, цаг хүндэрсэн үед ашиглахаар төлөвлөж байна. Бэлчээрийн төлөв байдал, доройтлын үнэлгээ сумдын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасаг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Швейцарийн Хөгжлийн агентлагийн “Ногоон алт” төсөлтэй хамтран фотомониторингийн аргаар бэлчээрийн хээрийн судалгааг бүх сумдад хийж дүн мэдээг Газрын харилцаа, геодези зурагзүйн газарт хүргүүлсэн. Судалгааны дүн 12 дугаар сард гарна.	100
77	3.1.6.Бэлчээр, хадлангийн талбайг зөв зохистой ашиглах журам боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Жилдээ	Хадлан бэлчээрийн эрх зүйн орчин сайжирсан байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 3 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор “Бэлчээр, хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг батлуулсан. Бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны А/317 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсэг нийт сумдад бодлогын хэрэгжилтийг хангуулах, гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр ажилласан. Зөрчил гаргасан 23 аж ахуйн нэгж, иргэнд аймгийн Засаг даргын 2017 оны А/403, А/404 дүгээр захирамжаар арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.	100
78	3.1.7.Орон нутгийн түүхий эдэд тулгуурлан бүрэн найрлагат мал амьтны тэжээлийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Малын тэжээлийн хангамж нэмэгдэнэ.	Аймгийн газар тариалангийн гол бүс нутаг болох Халхгол суманд “Алтай агро трейд” ХХК өөрийн хөрөнгөөр хорголжин тэжээлийн үйлдвэрийг байгуулан ажиллаж байна. Уг үйлдвэр нь цагт 5 тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай ба одоогийн байдлаар өөрийн агуулахад 2000 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлээд байна. Ингэснээр хувийн хэвшлийн оролцоотойгоор аймгийн хэмжээнд малын тэжээлийн хэрэгцээг 100 хувь хангах боломжтой болсон.	100
79	3.1.8.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан “Тэмээ” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилдээ	Тэмээний тоо толгойг өсгөх, чанарыг сайжруулах зорилгоор бойжиж буй ботгонд урамшуулал олгогдоно.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолоор “Тэмээ” дэд хөтөлбөрийг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/326 дугаар захирамжаар 14 сумын 831 толгой ботго бойжуулсан 313 малчин өрхөд 16,620,000 /арван зургаан сая зургаан зуун хорин мянга/ төгрөгийн урамшууллыг олгосон. Тэмээн сүргийн тоо толгой 5,6 хувиар өссөн.	100
3.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.					
80	3.2.1.“Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”-ыг	Жилдээ	Газар тариалангийн үйлдвэрлэл нэмэгдэнэ.	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2017 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсан “Улсын тариаланчдын зөвлөгөөн”-д аймгаас үр тариа, төмс хүнсний ногооны тариалан эрхлэгч аж ахуй нэгж,	100

	хэрэгжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулна.			төрийн байгууллагын төлөөлөл оролцсон 18 хүний бүрэлдэхүүнтэй багийг зохион байгуулж оролцуулсан. “Тариалалтын ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2017 оны А/213 дугаар захирамжийг сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Ургамал ургалтын хугацаанд тариалан бүхий сумдад 2-3 удаа мэргэжлийн баг ажиллаж, аймгийн “Газар тариалангийн талаар баримтлах бодлого”, “Тариалалтын ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2017 оны А/213 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Энэ онд тосны ургамлыг нийт тариалах талбайн 16,0 хувьд тариалсан.	
81	3.2.2.Усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, усан сан байгуулах, дэд бүтэц татахад дэмжлэг үзүүлж усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээд 2017 онд 635,1 га талбайд усалгаатай тариалан эрхэлж байгааг 2016 онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 127,5 га буюу 25,1 хувиар нэмэгдсэн. 2016 онд Хэрлэн сумын 5 дугаар багт 100 га талбайн услалтын системийн байгууламжийг бүрэн хийж, 2017 онд тус талбайд малын тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо тариалах туршилтын ажлыг “Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гүйцэтгэснээр усалгаатай талбайн хэмжээ өнгөрсөн оныхоос 100 га-аар нэмэгдсэн. Усалгаатай тариаланг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Халхгол суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Алтай групп” ХХК нь 5000 га талбайг усжуулах ажлын зураг төсөв боловсруулж байна.	70
82	3.2.3.“Төмс хүнсний ногооны зоорь” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж хэрэгжүүлнэ.	Жилдээ	Төмс, хүнсний ногооны хангамж нэмэгдэнэ.	“Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 2000 тн-ын багтаамжтай зоорийн аж ахуйн ажлыг эхлүүлээд байна. “Төмс, хүнсний ногооны зоорь” дэд хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	70
83	3.2.4.Өвлийн хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Жилдээ	Ажлын байр нэмэгдэж хүнсний аюулгүй байдал сайжирсан байна.	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас “Сатабу” ХХК-д өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах зориулалтаар 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, өвлийн хүлэмж барих ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. “Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь өөрийн нөөц бололцоогоо ашиглан 600м2 талбайд өвлийн хүлэмж байгуулж байна. Ажлын явц 80 хувьтай байна.	100
3.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.					
84	3.3.1.Хэрэглээний гол нэрийн барааны дотоодын үйлдвэрлэл, импортын судалгааг хийнэ.	Жилдээ	Иргэд, аж ахуйн нэгжийг мэдээллээр хангана.	Хэрэглээний гол нэрийн барааны судалгааг 2017 оны 2 дугаар сард эцсийн байдлаар гаргасан бөгөөд гол нэрийн 6 төрлийн дотоодын үйлдвэрлэл, импортын судалгааг аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэстэй хамтран хийж Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд танилцуулсан. Судалгааны дүнгээр 2016 онд гурилын үйлдвэрлэлээс 5,7 мянган тонн буудайн гурил үйлдвэрлэж хүн амын хэрэгцээг 100 хувь хангасан. Талх, нарийн боов	100

				<p>үйлдвэрлэх 48 цехэд 2016 онд 1,4 мянган тонн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэн хүн амын хэрэгцээ хангалт 23,0 хувьтай байна. Мал аж ахуйн салбараас жилд 8,7 мянган тонн сүү хүлээн авч хүн амын хэрэгцээний 76,1 хувийг хангаж байна. Мөн 300,6 мянган литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж байна.</p> <p>Мөн мал аж ахуйгаас 12,8 мянган тонн мах бэлтгэж хүн амын хэрэгцээг 100 хувь хангаж байна. Үүний 6-10 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна. 2016 онд 901,3 тонн хүнсний ногоо, 2338,0 тонн төмс хураан авч хэрэгцээт хүнсний ногооны 16,5 хувь, төмсний 61,2 хувийг хангаж байна. Нийт 12,0 мянган толгой бүхий 3 тахианы аж ахуйгаас жилд 176,8 тонн өндөг хүлээн авч аймгийн хүн амын хэрэгцээний 34,1 хувь, Чойбалсан хотын хүн амын хэрэгцээний 61,0 хувийг хангаж байна.</p>	
85	3.3.2.“Сар шинийн өнгө-2017” үзэсгэлэн худалдаа, “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл-2017” нэгдсэн уламжлалт арга хэмжээг зохион байгуулна.	1, 3 дугаар улирал	Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ.	Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Худалдаа аж үйлдвэрийн танхимын Дорнод аймгийн салбар, Дорнод их сургуультай хамтран 2017 оны 2 дугаар сард "Сар шинийн өнгө-2017" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд 50 гаруй иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцон 160,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Жил бүр уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл-2017” үзэсгэлэн худалдааг 2017 оны 9 дүгээр сард зохион байгуулж, 2 аймгийн 13 сумын 100 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хүнс, хөдөө аж ахуйн салбарын 11 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэж, 35,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Өмнөх онтой харьцуулахад борлуултын орлого 20 гаруй хувиар өссөн дүнтэй байна.	100
86	3.3.3.Чулуунхороот, Баян-Уул сумдад мах, махан бүтээгдэхүүний, Хэрлэн, Чойбалсан, Булган сумдад мах, сүү боловсруулах үйлдвэр шинээр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Ажлын байр нэмэгдэж, иргэдийн амьдралын түвшин дээшилсэн байна.	Энэ онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгогдоогүй болно.	Үнэлэх боломжгүй
87	3.3.4.Мэргэжлийн холбоодтой үйлдвэрлэлийн оновчтой сүлжээг зах зээлд бий болгоход хамтран ажиллана.	Жилдээ	Төрийн хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсан байна.	Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 2 дугаар бага хурал, Гэрэл зурагчдын холбооны 2 дугаар чуулган, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мастер тогооч нарын холбоод тус бүр үйл ажиллагаагаа сурталчилж, туршлага солилцон хамтарч ажиллан амжилттай оролцсон. Нэгдсэн үндэстний байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Нэмүү өртөгийн сүлжээ” төсөлтэй хамтран хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэгч, үйлдвэрлэл эрхлэгчдэд, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцсон Платформын уулзалтыг 2017 оны	100

				9 дүгээр сард зохион байгуулж, энэ чиглэлээр хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.	
88	3.3.5. Мал нядалгааны төвүүдийг стандартын шаардлагад нийцүүлнэ.	Жилдээ	Орчны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжирч хүнсний аюулгүй байдал хангагдсан байна.	Аймгийн хэмжээнд мал нядалгааны 11 төв үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
89	3.3.6. Биотехнологийн жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Судалгааны ажил хийгдэж, санал санаачилгыг дэмжсэн байна.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул дэмжлэг үзүүлэх боломжгүй болсон.	Үнэлэх боломжгүй
90	3.3.7. Ахуй үйлчилгээний аяныг зохион байгуулна.	Жилдээ	Аян зохион байгуулагдаж иргэдийн суурь үйлчилгээ хангагдсан байна.	Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсдын мэргэжил ур чадвар, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготойгоор “Ахуйн үйлчилгээ-2017” сарын аяныг 2017 оны 10 дугаар сарын 10-наас 1 сарын хугацаанд зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөг батлуулан, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар тус аяныг зохион байгуулах зардалд 1,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. Аяны хүрээнд салбарын ажилчдын сургалт семинар, спортын арга хэмжээ зохион байгуулж, Баян-Уул, Чойбалсан, Цагаан-Овоо Сэргэлэн сумдад явуулын ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлнэ.	40
91	3.3.8. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн шинэ техник технологи бүхий импортыг орлох экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл сонгон шалгаруулах уралдаан зохион байгуулна.	Жилдээ	Төслийг сонгон шалгаруулж, шалгарсан төсөлд гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай холбоно.	Төсөл сонгон шалгаруулах уралдааны шалгаруулалтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
3.4. Газрын тос, нүүрс, өнгөт төмөрлөг болон барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлснээр аймгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.					
92	3.4.1. Барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Барилгын материалын үйлдвэрлэл нэмэгдэнэ.	Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын зүгээс хууль эрхзүйн хүрээнд зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлж, бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдах, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулах, осол аваараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажилласан.	70
3.5. Байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй технологид суурилсан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аймгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангана. /Эрчим хүч/					

93	3.5.1. Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлэх орон нутгийн зүгээс эрчимтэй ажиллана.	Жилдээ	Эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдэх суурь тавигдана.	2017 онд “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хүчин чадлыг 50 мвт-аар өргөтгөх саналыг Эрчим хүчний сайдад хүргүүлж, Эрчим хүчний сайдтай аймгийн Засаг дарга 2017 онд хамтран ажиллах гэрээнд тусгуулсан. Мөн энэ онд Эрчим хүчний сайд 4, 6 дугаар сард аймагт ажиллах үеэр аймгийн Засаг дарга “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагааг танилцуулж, өргөтгөлийн ажлыг эрчимжүүлэх, эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай ажлын талаар санал солилцон саналаа албан бичгээр өгсөн. Өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдан Эрчим хүчний яаманд “Ситик” концерциум шалгаран гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. Санхүүжилтийн асуудал тодорхойгүй улмаас гэрээ байгуулах ажил удаашралтай.	100
94	3.5.2.Сумдын эрчим хүчний хүчин чадлын судалгаа хийнэ.	Жилдээ	Эрчим хүчний салбарт хийх хөрөнгө оруулалт оновчтой болно.	Аймгийн нийт 14 сумын эрчим хүчний хэрэглээ, хүчин чадлын судалгааг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-тай хамтран хийсэн. Шаардлагатай ажлуудыг 2018 оны хөрөнгө оруулалтад тусгахаар төлөвлөн ажиллаж байна.	100
3.6 Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.					
95	3.6.1.Чойбалсан хотын тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохио суурилуулна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсан байна.	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохио суурилуулах ажлын материал худалдан авах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчээр “МЗА” ХХК шалгарч, гэрээ байгуулан, бараа материалыг нийлүүлсэн. Хэрлэн сумын 7, 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт Бөхийн өргөөний зүүн урд талд, “Чадангууд” төвийн баруун хойд талын дөрвөн замын уулзварт 2 байршилд суурилуулах ажлыг “Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 70 хувь	70
96	3.6.2.Содномдаржаагийн гудамжнаас Хивс, Ялалтын гудамж дундуур шинээр баригдах 1.56 км хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилдээ	Гэр хорооллын иргэд дэд бүтцээр хангагдсан байна.	Ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Авто агро” ХХК Хэрлэн сумын 10 дугаар багийн нутаг дэвсгэрт Содномдаржаагийн гудамжнаас Хивс, Ялалтын гудамж дундуур гэрэлтүүлэг, явган зам бүхий 500 м хатуу хучилттай авто замыг орон нутгийн хөгжлийн сангийн 335,0 сая төгрөгийн хөрөнгөөр барьж, 2017 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулсан.	100
97	3.6.3.Чойбалсан хотын авто замд засвар, арчлалт хийж авто зогсоол байгуулна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжирсан байна.	Замын засвар арчлалт, зогсоол байгуулах ажлыг “Авто агро” ХХК-тай 5, 6 дугаар сард ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан зогсоол барьж дуусган ашиглалтад хүлээлгэн өгсөн, 13 байршилд засвар нөхөөсний ажил хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсан.	100
98	3.6.4.Чойбалсан хот-Ульхан боомт хүртэл баригдах хатуу хучилттай авто замын трассыг Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын авто замтай уялдуулах	Жилдээ	Иргэдийн амьдрах таатай орчин бүрдсэн байна.	Чойбалсан-Ульхан чиглэлийн хатуу хучилттай авто зам барих зураг төсөвт өөрчлөлт оруулах /Сэргэлэн, Цагаан-Овоо сумаар дайруулах/ саналыг Зам тээвэр хөгжлийн яаманд албан бичгээр хүргүүлсэн. Зам тээврийн хөгжлийн яамнаас хариу ирүүлээгүй байна.	40

	талаар судалж шийдвэрлүүлнэ.				
3.7 Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл холбооны үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ					
99	3.7.1.Хөдөөгийн алслагдсан багийн нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээний судалгаа хийх.	Жилдээ	Судалгаа хийгдсэн байна.	Сумдын үүрэн холбооны сүлжээний тархалтын судалгааг “Мэдээлэл, харилцаа холбоо” ТӨХК-ийн Дорнод аймгийн газартай хамтран хийсэн. Үүрэн холбооны сүлжээ дутагдалтай байгаа Халхгол сумын Ташгай баг, Чулуунхороот сумын Галуут багийг холбоожуулах саналыг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлж, “G-mobile” ХХК Халхгол сумын Ташгай багт сүлжээг оруулаад байна.	100
100	3.7.2.Орон нутгийн телевизийн нэвтрүүлгийг сумдад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	Жилдээ	Сумдын иргэд орон нутгийн мэдээллээр хангагдана.	Сумдад DDISH ТВ-ээр орон нутгийн “ТВ-6”, “Дорнод” “Мижи” телевиз, мөн үндэсний “Нутаг-21” телевиз цацагдаж байгаа бөгөөд сум орон нутгийн иргэд аймаг орон нутагтай холбоотой мэдээ мэдээллийг цаг алдалгүй шуурхайхүлээн авч байна.	100
3.8 Хот суурин газрын ус, дулаан хангамж, ариутгах татуургын найдвартай байдлыг хангаж, хүн амын тохитой,цэвэр орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.					
101	3.8.1.Чойбалсан хотод шинээр баригдах 1000 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээг өргөтгөх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.	Жилдээ	Нийт 3,0 км дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ баригдана.	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд “Аркетайп” ХХК-ийн гүйцэтгэсэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 48 га газарт баригдах орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эйч Жи Зет” ХХК 5,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр ажлыг гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлыг 2016 оноос эхэлж, ТК-10, ТК-11 хүртэлх гадна инженерийн шугам сүлжээний өргөтгөл, дэд өртөө, насосны станцын барилга, Ф359 мм-ийн голчтой 392 хос метр шугам хоолойг Ф426 мм-ийн голчтой шугам хоолойгоор өргөтгөн шинэчлэх ажил хийгдэж, шугам хоолойг ажиллагаанд залгаж хэрэглэгчдийг дулаанаар хангасан. 2017 онд дулааны шугамын газар шорооны ажил, шуудуун тэгшилгээ, ул бетоны цутгалт, ханын цутгалтын ажлууд бүрэн хийгдэж дуусан, насосын станцаас шугам хоолойн угсралт, 15 дугаар дулааны худгийн цутгалтын ажил, ариутгах татуургын шугам хоолой угсрах ажил хийгдэж байна. Ажлын явц 70 хувьтай.	70
102	3.8.2.“Шинэ усан сан” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	Жилдээ	Ундны усны эрүүл ахуйн нөхцөл сайжирсан байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Шинэ усан сан” төслийн хүрээнд Хэрлэн сумын 10 дугаар багт Уурхайчин хороололд шинээр усан сангийн барилга барих ажлыг “Дорнын оч” ХХК, 7 дугаар багт Ус түгээх 8 дугаар байрны барилгын засвар шинэчлэлтийн ажил, 1 дүгээр багт Усан сан-13, 14-ийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашаа, хайс хийх ажлыг “Донж өргөө” ХХК тус тус гэрээ байгуулан ажиллаж, ашиглалтад оруулсан.	100
3.9 Хоггүй цэвэр, эмх цэгцтэй, цэвэр агаартай, ногоон байгууламжтай хот, сууринг байгуулахад чиглэсэн алхам /Хот төлөвлөлт, газрын асуудал/					

103	3.9.1.Хэрлэн сумын 4 дүгээр багт шинээр баригдсан 400 метр хатуу хучилттай авто замын дагуу гэрэлтүүлэг хийнэ.	Жилдээ	Иргэдийн аюулгүй зорчих орчин бүрдсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн 22,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 4 дүгээр багт шинээр баригдсан 400 метр хатуу хучилттай авто замын дагуу гэрэлтүүлэг тавих ажлын материалыг “МЗА” ХХК нийлүүлж, суурилуулах ажлыг “Гэрэл сэтгэмж” ХХК гүйцэтгэн, ашиглалтад оруулсан.	100
104	3.9.2.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримталж газрын харилцааны асуудлыг шийдвэрлэж ажиллана.	Жилдээ	Чойбалсан хот төлөвлөлтийн дагуу хөгжих боломж бүрдсэн байна.	Монгол Улсын Газрын тухай багц хуулийн хүрээнд сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тухайн жилд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох асуудлыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газарт хүргүүлсэн. Энэ онд Дорнод аймгийн хэмжээнд иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 290,9 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс Баянтүмэн суманд 63 иргэнд 5,67 га, Баян-Уул суманд 33 иргэнд 7,14 га, Дашбалбар суманд 6 иргэнд 1,7 га, Сэргэлэн суманд 1 иргэнд 0,075 га, Хэрлэн суманд 136 иргэнд 9,45 га, нийт 238 иргэнд 24,0 га газрыг тус тус өмчлүүлсэн. Аймгийн Засаг даргын 2017 оны А/240 дүгээр захирамжаар Засаг даргын дэргэдэх Хот байгуулалтын орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, ажиллах журмыг баталсан. Зөвлөл энэ онд 5 удаа хуралдаж, газрын харилцаа, хот төлөвлөлттэй холбоотой 750 орчим иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэлэлцэж холбогдох шийдвэрийг гарган ажиллалаа. Сүүлийн жилүүдэд аймгийн төвийн агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэж байгаатай холбогдуулан Хэрлэн сумын зонхилох салхины дээд хэсэг болох 2, 3, 4, 10 дугаар багийн одоо байгаа гэр хорооллын хойд талд шинээр нэмж гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгохгүй байх талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
3.10 Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн хангасан, амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хот сууринг хөгжүүлнэ. /Барилга байгууламж/					
105	3.10.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжийн ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана.	Жилдээ	Хөрөнгө оруулалтын ажил чанартай хийгдсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга, 1000 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажлын явц 85 хувьтай, хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил 70 хувьтай байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын багцаас санхүүжин хэрэгжсэн барилга угсралт, засварын 13 ажлын гүйцэтгэгийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж ажилласан.	70

106	3.10.2.“Барилгачдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулна.	4 дүгээр улирал	Барилгын салбарын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэсэн байна.	“Аймгийн Барилгачдын зөвлөгөөн”-ийг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
107	3.10.3.“Барилга экспо-2017” барилга, орон сууц, барилгын материалын үзэсгэлэн яармаг зохион байгуулна.	3 дугаар улирал	Иргэд аж ахуйн нэгж салбарын мэдээллээр хангагдсан байна.	“Барилга экспо-2017” барилга, орон сууц, барилгын материалын үзэсгэлэн яармагийг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулна.	Хугацаа болоогүй
108	3.10.4.Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хуучин барилгыг өргөтгөх, давхар нэмэх талаар судалгаа хийнэ.	Жилдээ	Сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээ нэмэгдэх боломж бүрдэнэ.	Сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн өмчийн барилгуудыг цэцэрлэг, бага сургуулийн зориулалтаар засварлан ашиглах ажлын хүрээнд Хан-Уул цогцолбор сургуулийн 6 настны хичээлийн байрыг 75 хүүхдийн цэцэрлэг болгох, Хан-Уул цогцолбор сургуулийн хичээлийн шинэ байрны зүүн хойд талын одоо ашиглалтгүй байгаа байрыг 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг болгох, Хэрлэн сумын 6 дугаар багт Ивээл хороололд байрлах Ахмадын өвлийн сувиллын байрыг 150 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг болгох, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хуучин байранд 22 бүлэг 660 сурагчтай бага сургууль байгуулах урсгал засвар хийх, Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн хичээлийн хуучин байранд 23 бүлэг, 690 сурагчтай бага сургууль байгуулах урсгал засвар хийх саналыг боловсруулсан. Хан-Уул цогцолбор сургуулийн 6 настны сургуулийг цэцэрлэгийн зориулалтаар ашиглах зураг төсвийг “Талын хас” ХХК-тай гэрээ байгуулан хийлгэсэн. Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон өөрчилж, их засварын ажлыг гүйцэтгэн, Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг ашиглалтад оруулсан.	70
3.11. Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, төсвийн байгууллагын албан хаагчид болон иргэд төсвөө хянах, төсвийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилтыг хангана.					
109	3.11.1.Сумдын төрийн сан, төсвийн байгууллагуудын төсөв, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өмнөх оны хяналт шалгалтын ажлын үр дүнг сайжруулна.	Жилдээ	Сумдын төрийн санд дотоод аудит, хяналт шалгалт хийгдсэн байна.	Аймгийн Засаг даргын 2017 оны А/164 тоот захирамжаар Сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналт хийх календарчилсан төлөвлөгөөг боловсруулж Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаал “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу 2017 оны 5 дугаар сарын 08-14-ний өдрүүдэд Хөлөнбуйр, Булган суманд, 5 дугаар сарын 22-28-ны өдрүүдэд Чулуунхороот, Гурванзагал, Дашбалбар, Чойбалсан сумдын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын явцад өмнөх жилийн төрийн сангийн дотоод хяналт шалгалтаар гарсан зөрчил, түүний дагуу өгсөн зөвлөмжийн биелэлт, авч хэрэгжүүлсэн ажилд дүгнэлт хийхэд Булган, Хөлөнбуйр, Гурванзагал сумд өмнөх жилд гарсан зөрчлийг давтан гаргасан. Чулуунхороот, Дашбалбар сумд зөвлөмжийн дагуу ажлыг зохион байгуулж, зөрчлийг арилган ажилласан байна. Энэхүү	70

				ажлын хүрээнд санхүүгийн албаны үйл ажиллагаанд гарсан зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөвлөмж өгч, санхүүгийн ажилтнуудад шинэчлэгдсэн төсөв санхүүтэй холбоотой заавар журам, 2016 оны УИХ-ын 47 дугаар тогтоолыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах, учирч болох эрсдэлийг бууруулах зорилгоор мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Энэ сарын 9-нөөс 16-ны өдрүүдэд Санхүүгийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг Сэргэлэн, Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун сумдад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
110	3.11.2.Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хамрах хүрээний бүх шатны төсөвт эерэг, сөрөг хандлагуудыг тэнцвэржүүлэн, аймгийн 2017 оны төсвийн тэнцлийг бүрэн хангаж ажиллана.	Жилдээ	Төсвийн тэнцэл алдагдалгүй гарсан байна.	Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар, “2017 оны төсвийн тухай” хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэгдэн батлагдаж, Дорнод аймагт шилжүүлэх орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, улсын төсвөөс аймагт олгох санхүүгийн дэмжлэг, тус тус өөрчлөлт орсон тул Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-дэх заалтыг үндэслэн аймгийн 2017 оны батлагдсан төсөвт, нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар төсвийн тодотголыг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр баталсан. Тодотголоор орон нутгийн төсвийн орлогыг 364,9 сая төгрөгөөр бууруулж, төсвийн зарлагыг 1,460,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн урьд оны глдэгдлээс 1,825,2 сая төгрөгийг энэ оны төсөвт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.	70
111	3.11.3.Төсвийн мэдээллийн ил тод, үнэн зөв зарчмыг хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд санхүү, төсвийн програмын шинэчлэлийг хийж, сумдын болон төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтан, албан хаагчдад салбарын шинэчилсэн програм хангамж, бүртгэл, санхүү, төсвийн хуулийн талаарх сургалтыг зохион байгуулна.	Жилдээ	Санхүү, төсвийн шинэчилсэн програм худалдан авсан, сургалт зохион байгуулагдсан байна.	Орон нутгийн төсөв, санхүүгийн ажилтны чадавхыг бэхжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, орон нутгийн төрийн сангийн үйлчилгээнд гарах эрсдэлийг бууруулах зорилгоор, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, соёлын байгууллагуудын төсвийн шууд захирагч болон төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт төсвийн төлөвлөлтийн тухай сургалтыг 2017 оны 6 дугаар сарын 26-нд, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн В7 хувилбарын танилцуулга, мэргэшүүлэх сургалтыг аймгийн төв Хэрлэн суманд 2017 оны 6 дугаар сарын 27-28-нд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын сургалт 29-30-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 217 хүн хамрагдсан. Төсвийн мэдээллийн ил тод, үнэн зөв зарчмыг хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд санхүү, төсвийн програмын шинэчлэл хийх ажлын хірээнд сумдын боловсролын салбарын байгууллагуудын нягтлан бодох біртгэлийн програмын шинэчлэлийг хийсэн болно.	100
112	3.11.4.Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд улсын үзлэг тооллогын дүн мэдээнд тулгуурлан эд хөрөнгийн	Жилдээ	Төрийн байгууллагуудтай харилцах уялдаа холбоо сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажилласан. Өмчийн хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төсвийн	70

	харилцааны талаар хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан ажиллана.			орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтарсан удирдамж боловсруулан хөдөөгийн Булган, Хөлөнбуйр, Чулуунхороот, Дашбалбар, Гурванзагал, Чойбалсан, Хэрлэн зэрэг нийт 6 сумдад ажилласан. Аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажилласнаар орон нутгийн төсөвт 8,5 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан байна.	
113	3.11.5.Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон, үйл ажиллагааны менежментийг сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Жилдээ	Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, үйл ажиллагааны менежмент сайжирна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтнуудтай хамтран Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 10 газрын удирдлагуудад үйл ажиллагааны менежментийг хэрхэн сайжруулах, техник эдийн засгийн үндэслэлийн боловсруулах, бүтэц орон тоо, ажилтнуудын гүйцэтгэх үүрэг чиглэлээр уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан. Хөдөөгийн 6 сумдын удирдлага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилтнуудтай уулзаж, үйл ажиллагаа менежментийг сайжруулах чиглэлээр санал бодол солилцож, бусад байгууллагын туршлага болон ажиллах арга чиглэл өгч ажилласан. Мөн 6 сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нартай Өмч эзэмшлийн гэрээ байгуулан ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар уламжлуулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд байна.	70
114	3.11.6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуулийн дагуу ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан зохион байгуулна.	Жилдээ	Холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тодотгосон нийт 3,9 тэрбум төгрөгийн 83 төсөл, арга хэмжээ тусгасан. Үүнээс 98 хувь буюу 81 төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт ирснийг тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Эрх шилжүүлж ирсэн 1 төсөл, сүүлд тодотголоор нэмэгдсэн 1 төсөл арга хэмжээний зураг төсөв ирээгүй, худалдан авах ажиллагаа хүлээгдэж байна. Зохион байгуулсан 81 тендер шалгаруулалтад давхардсан тоогоор 144 оролцогч оролцсон байна. 2017 оны 9 сарын байдлаар тендер зохион байгуулалтын 1р дүнд, Улсын төсвөөс 109,7 сая, Орон нутгийн төсвөөс 72,3 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 56,0 сая, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангаас 17,8 сая төгрөг нийт 255,8 сая төгрөгийн хэмнэлт хийгдсэн байна.	70
115	3.11.7.Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нийт тендер шалгаруулалтын 50-аас	Жилдээ	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Шилэн тендер”	Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор зарласан нийт 74 тендер шалгаруулалтын 60 хувь нь буюу 44 тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийг ашиглан зохион байгуулж, урилга, үр дүнг нийтлэн ажиллаж байна.	100

	доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулна.		бодлого хэрэгжилт хангагдана.		
116	3.11.8. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн, албан хаагчид болон тендерт оролцогчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.	Жилдээ	Худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтад оролцогчдын мэдлэг чадвар сайжирсан байна.	Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох "А-3" сургалтыг 2 удаа зохион байгуулж 110 хүн хамрагдснаас 68 хүн гэрчилгээтэй болсон байна. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтыг төрийн байгууллага, аж ахуйн нэгжид явуулж 62 хүн оролцсон байна.	100
117	3.11.9. Орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа барилга байгууламжуудын ашиглалтыг сайжруулах талаар санал санаачилгатай ажиллана.	Жилдээ	Орон нутгийн өмчийн ашиглалт сайжирсан байна.	Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчид бүртгэлтэй нийт 694 нэр төрлийн барилга байгууламж байна. Үүнээс цэцэрлэг, сургуулийн зориулалтаар ашиглаж болох барилгын судалгааг гаргасан бөгөөд Хан-Уул цогцолбор сургуулийн харьяа 6 настай бүлгийн барилга, Хан-Уул цогцолбор сургуулийн харьяа хичээлийн хуучин байрны зүүн корпусын барилга, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хуучин хичээлийн барилга, Хэрлэн сумын 1 дүгээр багийн ажлын албаны барилга, аймгийн Засаг дарын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа ахмадын өвлийн сувиллын барилга, хуучин 12 дугаар сургуулийн аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй барилгуудыг тодорхойлоод байна. Мөн орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга байгууламж, эд хөрөнгийг ашиглуулах, 13 ашиглалтын гэрээг шинэчлэн байгуулж хяналтдаа аван ажиллаж байна.	70
Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогын хүрээнд:					
4.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль журмыг чанд мөрдүүлж ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.					
118	4.1.1.Эрдэс баялагийн салбарт байгаль орчны талаарх хуулийн хэрэгжилт явцын хяналт тавьж нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах, зөвлөн туслах ажлын тоо давтамжийг нэмэгдүүлэн хариуцлагыг өндөржүүлнэ.	Жилдээ	Стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна.	Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалт, хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны салбарын хууль тогтоомж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, газрын нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах, зөвлөн туслах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна. Баяндун, Дашбалбар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 6 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2017 оны 5 дугаар сард, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд 2017 оны 6 дугаар сард, Халхгол суманд газрын тосны олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж "Петро чайна дачин тамсаг" ХХК-ийн гэрээт 21 дүгээр талбайн үйл ажиллагаанд 2017 оны 9 дүгээр сард тус тус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, заавар зөвлөмж өгсөн. Аймгийн Засаг даргын 2014 оны А/402, 2016 оны А/410 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2017 оны 11 дүгээр сард багтаан энэ онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулан үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулна.	70

4.2 Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээж, усны нөөцөө хамгаалах, хомсдолоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.					
119	4.2.1.Хэрлэн сумын 3 дугаар багт ойн зурвас, ногоон байгууламж байгуулна.	2.3 дугаар улирал	Хотын өнгө үзэмж, орчны эрүүл ахуй сайжирсан байна.	Ойн зурвас байгуулахад шаардлагатай бараа нийлүүлэх тендерт гүйцэтгэгчээр “Баянлуу” ХХК шалгаран ажлын даалгаварт тусгагдсан бараа материалыг “Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэн өгсөн. “Гэрэл сэтгэмж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 10 га-д ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 1100 метр урт, 35 метрийн өргөнтэй 3 хэсэг төмөр торон хашлага хийж, 4400 ширхэг улиас, хайлаас, гүйлс модыг тарьж, арчилгааг хариуцан ажиллаж байна.	70
120	4.2.2.Мод тарих ажлыг аймгийн хэмжээнд бүх нийтийг хамруулан зохион байгуулна.	2,4 дүгээр улирал	Төв, суурин газрын ногоон байгууламж нэмэгдэж орчны тоосжилт, агаарын хуурайшилт буурсан байна.	Ийгэе бөһүг Айрбөөеэа+еэй “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 ийү 63 аооаад чабөөа, Дорнод аймгийн Засаг даргын 2016 оны өдрийн А/388 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2017 оны Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 5,0 сая төгрөгийн төсөв батлуулан 12 ажил бүхий төлөвлөгөөг батлуулж, хаврын мод тарилтыг 2017 оны 5дугаар сард “Тарьсан модоо арчлан ургуулцаая” уриан дор зохион байгуулсан. Аймгийн дүнгээр хаврын мод тарилтын 11 байршилд 134 байгууллага, 8725 иргэн оролцож 45,7 сая төгрөгийн зардлаар гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнд 24059 ширхэг мод тарьсан. Мөн мод тарих үндэсний өдрийг угтан “Тарьц суулгац-2017” үзэсгэлэн худалдааг Баян-Уул, Баянтүмэн, Хэрлэн сумдтай хамтран 5 дугаар сард зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд 8 иргэн өөрсдийн тарьж ургуулсан 12 төрлийн модны 3000 гаруй тарьц, суулгацыг худалдан борлуулж 5,2 сая төгрөгийн орлого олсон байна. Тарьц суулгацаар хангах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Солонгосын “Ногоон хэрэм” төсөлд хүсэлт тавьсны дагуу 9000 ширхэг хайлаас, 1000 ширхэг сухай, нийт 10000 ширхэг суулгацыг Дорнод аймгийн ногоон байгууламжид хандивласан. Иргэд нөхөрлөлийн ургуулсан тарьц суулгацыг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 5 иргэнээс 2248 ширхэг навчит модны суулгацыг 4,0 сая төгрөгөөр худалдан авч нийт 12148 ширхэг навчит модны суулгацаар хангасан байна. Намрын мод тарилтын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 7-ний өдөр зохион байгуулсан. Одоогоор нэгдсэн дүн мэдээ гараагүй байна.	70
121	4.2.3.Баян-Уул, Баяндун, Цагаан-Овоо, Халхгол сумдад нийт 100 га талбайд ойжуулалтын ажил хийнэ.	2 дугаар улирал	Ойн талбайг нэмэгдүүлсэн байна.	Баян-Уул сумын нутаг “Санжаа даваа” нэртэй газарт 70 га-д, Цагаан-Овоо сумын нутаг “Гүн цэнгэлэг” нуурын орчимд 10 га-д, Халхгол сумын нутаг “Хадан хясаа” нэртэй газарт 10 га-д талбайд, нийт 90 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээг ойн мэргэжлийн байгууллага “Баваж Барас” ХХК-тай байгуулсан. Ажлын даалгаварт заагдсаны дагуу 5 дугаар сараас 90 га талбайг ойжуулан арчлан ургуулж байна.	70

				<p>Баяндун сумын нутаг “Аргалантын булаг” нэртэй газарт 2 га-д, “Тээгийн өвөр” нэртэй газарт 8 га-д, нийт 10 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэх шууд гэрээг Баяндун сумын “Үлийн даваа” нөхөрлөлтэй байгуулж, 5 дугаар сараас ойжуулалтын ажлыг хийж, арчлан ургуулж байна.</p> <p>Захиалагч байгууллагын зүгээс явцын хяналтыг 2 удаа хийж холбогдох заавар зөвлөмжийг өгч ажилласан ба Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ажлын хэсгээс ажлын явцтай газар дээр нь танилцан “хангалттай сайн” үнэлгээг өгсөн.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс модны амьдралт ургалтын тооллогыг хийж, хүлээн авах ажлыг 10 дугаар сард зохион байгуулна.</p>	
122	4.2.4.Нарсны үр бэлтгэх талбай тусгаарлан түймрээс хамгаалах зурвас байгуулна. /Баян-Уул сум/	2 дугаар улирал	Үр бэлтгэх талбай түймрээс хамгаалагдсан байна.	<p>Баян-Уул сумын Засаг даргад эрх шилжүүлсний дагуу тус сумын 1 дүгээр багийн нутаг “Хархираа өндөр” хэмээх ойн сан бүхий 3 га талбайд нарсны үр бэлтгэх байнгын талбайг тусгаарлах, түймрээс хамгаалах зурвас татах ажлыг “Өвөр Эрээн” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 6 дугаар сард ажлыг хүлээн авсан.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд үр өгч байгаа 300 ширхэг модыг дугаарлах, тусгаарлах, тэмдэгжүүлэх, талбайг тойруулан түймрээс хамгаалах зурвас татах ажлыг гүйцэтгэсэн.</p>	100
123	4.2.5.Сум дундын ойн ангид боргоцой хатааж, үр бэлтгэх тоног төхөөрөмж тээвэрлэх зардалд дэмжлэг үзүүлнэ.	Жилдээ	Тоног төхөөрөмжийг БНХАУ-ын Шандун мужаас Баян-Уул суманд тээвэрлэн авчирч, угсран ашиглалтад оруулсан байна.	<p>“Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” МОН/12/301 төсөлд хүсэлт тавьсны дагуу Баян-уул суман дахь Сум дундын Ойн ангид боргоцой хатаалгын тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх тендерийг зарласан.</p> <p>Тендэрт “Залуу төгөл” ХХК шалгарч, төрөл бүрийн модны үр цэвэрлэгч машин 5FS-100, нарсны үрийг халуун агаарын эргэлтээр хатаах хатаалгын цахилгаан зуух СТ-С-1, хатаасан боргоцой бутлагч цахилгаан машинуудыг нийт 9975 ам.доллараар нийлүүлэх гэрээг МОН/12/301 төсөлтэй байгуулсан.</p> <p>Тоног төхөөрөмжийг 2017 оны 6 дугаар сарын 25-нд нийлүүлэн ашиглалтад оруулсан.</p>	100
124	4.2.6.Сумдын иргэд, нөхөрлөлийн ургуулсан тарьц, суулгацыг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлнэ.	2.3 дугаар улирал	Мод тарьж ургуулж байгаа иргэд, нөхөрлөлийн үйл ажиллагаа сайжирсан байна.	<p>Шилмүүст модны тарьц, навчит модны суулгацыг худалдан авч сумдын иргэд, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсний дагуу 10 иргэн, 2 ойн нөхөрлөлийн ургуулсан нарс, шинэс модны MNS6140:2010 стандартын 2-3 настай 54510 ширхэг, стандартын шаардлага хангасан тарьцыг 7,897,500 төгрөгөөр, Хэрлэн, Баян-уул сумдын 1 нөхөрлөл, 5 иргэнээс навчит модны 4 төрлийн 2248 ширхэг суулгацыг 4,102,500 төгрөгөөр худалдан авсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 15 иргэн, 3 ойн нөхөрлөлийн ургуулсан тарьц суулгацыг худалдан борлуулахад 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Иргэд, нөхөрлөлүүдээс худалдан авсан тарьц, суулгацыг Агро парк, Халхгол, Хөлөнбуйр, Булган, Цагаан-Овоо, Сэргэлэн сумдын Засаг даргын Тамгын газар, Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2, 5, 8 дугаар сургуулиуд, Мэнэн</p>	100

				дэх хилийн 306 дугаар анги, “Шинэ Бунхан” төрийн бус байгууллага зэрэг газруудад хуваарилан тариулж, 45,2-100 хувийн амьдралттай ургуулж байна.	
125	4.2.7.Халхгол сумын төвд хөв цөөрөм байгуулна.	Жилдээ	Усны нөөцийг хамгаалах, үр ашигтай зарцуулах боломж бүрдсэн байна.	Халхгол сумын төвд хөв цөөрөм байгуулах ажлын зураг төслийг усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөлтэй “Гидро Фантон” ХХК гүйцэтгэсэн. Хөв цөөрөм байгуулах ажлын тендерт усны барилга байгууламжийн “Вэлмот” ХХК шалгарч аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгэсэн. Аймгийн Засаг даргын 2017 оны А/417 дугаар захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2017 оны 9 дүгээр сард хүлээн авч ашиглалтад оруулаад байна.	100
126	4.2.8.Матад сумын Баруун нууранд хөв цөөрөм байгуулна.		Усны нөөцийг хамгаалах, үр ашигтай зарцуулах боломж бүрдсэн байна.	Матад сумын Баруун нуур нэртэй газарт хөв цөөрөм байгуулах ажлын зураг төслийг усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөлтэй “Гидро Фантон” ХХК хийж гүйцэтгэсэн. Хөв цөөрөм байгуулах ажлын тендерт усны барилга байгууламжийн “Вэлмот” ХХК шалгарч аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 75 хувьтай явагдаж байна.	70
127	4.2.9.Гурванзагал, Баяндун суманд байгуулагдсан хөв цөөрмийг засварлаж, хашаажуулан хамгаална.	Жилдээ	Усны нөөцийг хамгаалах, үр ашигтай зарцуулах боломж бүрдсэн байна.	Ажлын гүйцэтгэгчээр “Дорнын их дөл” ХХК шалгарч аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, 10 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	70
128	4.2.10.Булаг, рашааны эхийг хамгаалах, тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Жилдээ	Экологийн тэнцвэрт байдал хангагдсан байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 20,0 сая төгрөгийн зардлаар: “Хараат номчин” ХХК Баянтүмэн сумын нутаг “Зуухтын булаг”, Баян-Уул сумын нутаг “Бумбат булаг”-ийг, “Дорнын тэнхлэг” ХХК Сэргэлэн сумын нутаг “Хүйтний булаг”-ийг, “Техникийн цогц шийдэл” ХХК Чойбалсан сумын нутаг “Шар булаг”-ийн эхийг хамгаалах, тохижуулах ажлыг тус тус гэрээ байгуулан гүйцэтгэж, комисст хүлээлгэн өгсөн.	100
129	4.2.11.Хэрлэн голын усны харуулын ажиллах орчинг сайжруулна.	Жилдээ	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	“Оллсольюшн” ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, ажлын даалгаварт заагдсаны дагуу 6 нэр төрлийн завь, автомат багаж, тоног төхөөрөмжийг суурилуулан хүлээлгэн өгч, усны харуулын хэмжилтийн ажлын байрыг ашиглалтад оруулсан.	100
130	4.2.12.Хэрлэн голын сав газар дагуу хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоож тэмдэгжүүлнэ.	Жилдээ	Хуулийн хэрэгжилт хангагдана.	Дорнод аймгийн Хөлөнбуйр, Матад, Баянтүмэн, Булган, Хэрлэн, Чойбалсан, Сэргэлэн, Баян-Уул, Баяндун, Цагаан-Овоо сумын Хэрлэн голын сав газарт хамаарагдах нутаг дэвсгэрт “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох, тэмдэгжүүлэх” ажлыг зохион байгуулахаар аймгийн Засаг даргын дэргэдэх	70

				<p>Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хэрлэн голын сав газрын захиргаад гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Бүс тогтоох ажлын хүрээнд хээрийн судалгааны ажил хийгдэж дуусан, эрүүл ахуйн бүсийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах бичиг баримтыг боловсруулах, зураглал хийх ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>Хэрлэн голын эрэг дагуу тэмдэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчээр “Цахим хийц” ХХК шалгарч Булган, Хөлөнбуйр, Хэрлэн, Чойбалсан суманд нийт 15 ш анхааруулга санамж бүхий самбар хийж байршуулан аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017 оны А/06 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.</p> <p>Аймгийн Засаг даргын санаачлагаар Хэрлэн гол, түүний ай савыг хамгаалах, урсацыг нэмэгдүүлэх, ус ашиглалтад хяналт тавих зорилго бүхий “Нэг голын хүүхдүүд” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Тус төслийг дэмжин аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар, Сургуулийн Эко клубын багш, сурагчид эх дэлхий, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах үйлсэд нэгдэхийг уриалах зорилгоор гар зургийн уралдаан, байгаль орчноо хамгаалах, хог хаяхгүй байхыг анхааруулсан самбарыг хийж байршуулсан.</p>	
131	4.2.13.Хөх нуурын экосистемийн судалгааг хийлгэнэ.	Жилдээ	Хөх нуурын усны түвшин болон экосистемийн судалгаа хийгдсэн байна.	<p>“Хөх нуурын экосистемийн судалгаа хийх” ажлын гүйцэтгэгчээр “Хүрэн баавгай” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж, ажлын даалгаварт заагдсан нуурын усны түвшин болон экосистемийн судалгааг хийж, хөрс уснаас 20 байршлаас 30 төрлийн дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, дээжийн хариу, судалгааны ажлын явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн Дорнод хамгаалалтын захиргаа, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын төлөөллүүдийг оролцуулан танилцуулсан.</p> <p>Гэрээний дагуу 10 дугаар сарын 10-ны дотор ажлаа хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>	70
132	4.2.14.Уул уурхайн нөлөөлөлд өртсөн газрын хөрс, усны дээжийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.	Жилдээ	Хөрс, усны нарийвчилсан шинжилгээ хийлгэсэн байна.	<p>Уул уурхайн нөлөөлөлд өртсөн газарт хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу хөрс, усны дээж авах газруудын судалгааг сумдаас авч нэгтгэн дүгнэж, дээж авах нэн шаардлагатай “Шинь Шинь” уурхай, “Цагаан Чулуут” орд зэрэг газруудад ажлын хэсэг ажиллан дээж авч Ус, цаг уур, орчны шинжилгээний лабораторид хүргүүлээд байна.</p>	70
133	4.2.15.Ерөнхий боловсролын сургуулиудад “Эко сургууль” хөтөлбөр хэрэгжүүлж, сурагчдад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	Жилдээ	Сурагчдын экологийн боловсрол дээшилсэн байна.	<p>Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, “Байгаль орчин мэдээлэл сургалтын төв”-тэй хамтран “Эко сургууль” сургалтын хөтөлбөрийн хүрээнд эхний үе шатны сургалтыг Ерөнхий боловсролын 2, 5, 8 дугаар сургуулиудын байгалийн ухааны багш, сурагчид нийт 50 хүнийг хамруулан, 2 дахь удаагийн сургалтыг</p>	70

	талаар мэдлэг олгож, байгаль орчинд ээлтэй бүтээлч санал, санаачилгыг дэмжинэ. /Хэрлэн, Баян-Уул, Цагаан-Овоо сумын ЕБС/			Баян-Уул, Цагаан-Овоо сумын дунд сургууль, аймгийн Ерөнхий боловсролын 2, 5, 8 дугаар сургуулиудын байгалийн ухааны багш, сурагчид нийт 60 хүнийг хамруулан зохион байгуулсан ба эдгээр сургуулиудыг түшиц эко сургууль болгохоор зорин ажиллаж байна. 3 дахь шатны сургалт 2017 оны 10 дугаар сард хийхээр төлөвлөсөн.	
134	4.2.16.Байгалийн хүчин зүйлийн улмаас идэш тэжээл ховордсон зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авна.	1 дүгээр улирал	Зэрлэг ан амьтдад тэжээлээр хангагдсан байна.	Цагаан-Овоо сумын “Ухна”, “Шалз-таван толгой”, “Онцгой”, Баян-Уул сумын “Бардан”, “Хээр морьт” гэдэг газруудад цас их орсны улмаас өвөлжилт хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл хомсдож байсан тул “Байгаль орчныг хамгаалах” тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4, “Амьтны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 01/696 албан тоотын дагуу биотехникийн арга хэмжээ авах ажлын хүрээнд 20кг жинтэй 300 боодол өвс, 1,5 тонн хужир, шүүг “Бардан”, “Хээр морьт”, “Ухна”, “Онцгой”, “Шалз-таван толгой” зэрэг газруудаар тавьж өгөх ажлыг зохион байгуулсан. Уг газруудад 2016 оны ан амьтны тооллогоор 77 буга, 57 бор гөрөөс, 23 зэрлэг гахай болон цагаан зээр тоологдсон байна.	100
135	4.2.17.Үүлэнд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулж, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлнэ.	1,4 дүгээр улирал	Хуурайшилттай цаг үед үүлэнд зориудаар нөлөөлж бэлчээр, таримлын ургац нэмэгдсэн байна.	Үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадас оруулах ажлыг Орон нутгийн төсвийн хөрөнгөөс санхүүжүүлж, аймгийн Засаг даргын дэргэдэх Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын “Онон бороо” экспедиц, “Халхгол бороо” экспедицтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ онд газар тариалангийн бүс нутаг Халхгол суманд “Халхгол бороо” экспедиц шинээр байгуулагдсан. “Онон-бороо” экспедиц нь энэ оны 5,6 дугаар сард 17 удаа 27 цэгт 40 пуужин харваж, “Халхгол бороо” экспедиц 7 удаагийн гаралтаар 10 цэгт 12 пуужингаар үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг гүйцэтгэсэн байна.	100
136	4.2.18.Байгалийн баялаг, ашигт малтмалын зүй бус ашиглалт, хууль бус ан, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт тавих зорилгоор шаардлагатай цэгт камер суурилуулна.	Жилдээ	Байгаль орчинг хамгаалах хяналт сайжирсан байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Чойбалсан хотын Зүүн, баруун цементэн гүүр, дунд Модон гүүрэн дээр хяналтын камерыг хянаж байрлуулах зорилготой бараа материал, тоног төхөөрөмж нийлүүлэх тендер зарлан гүйцэтгэгчээр “Дорнын арвижих” ХХК шалгаран гэрээний дагуу материал хүлээлгэж өгөх хүсэлт гаргасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/469 дүгээр захирамжаар материал хүлээн авах ажлын комисс байгуулагдан ажиллаж байна.	40
137	4.2.19.Усны тооллого зохион байгуулна. /Матад сум/	Жилдээ	Уст цэгийн тоог тогтоож харилцан мэдээлэлтэй болно.	Матад сум, Буйр нуур, Мэнэнгийн сав газарт хамаарагдах нутаг дэвсгэрт усны тооллого хийх ажлын гэрээг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Буйр нуур, Мэнэнгийн сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээний дагуу усны тооллогын ажлыг 8 дугаар сард хийж дуусган мэдээ тайланг хүлээлгэн өгсөн.	100
138	4.2.20.Шаазан нуурын усыг сэргээх арга хэмжээг зохион байгуулна. /Баянтүмэн сум/	Жилдээ	Нуурын эко систем сайжирсан байна.	“Шаазан нуур”-ын усыг сэргээх ажлыг “Дорнын их дөл” ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Шаазан нуурын Хэрлэн голтой холбогдож байгаа сувгийн ханыг бетонон хавтангаар доторлон, сувгийн эхэн хэсгийн эргийг тэгшилж, сувагт хураагдсан	100

				лаг хураагуурыг зайлуулан цэвэрлэсэн. Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг 7 сард хүлээн авсан.	
139	4.2.21.Буйр нуурын эрэг орчмыг цэвэрлэх, загасны нөөцийг хамгаалах арга хэмжээ авна.	Жилдээ	Нуурын эко систем сайжирсан байна.	Буйр нуурын эрэг орчмыг цэвэрлэх, загасны нөөцийг хамгаалах ажлын тендерт “Буйрын толио” ХХК Буйр нуур болон Халхголын цутгал орчимд байгаа Тураг гогойны тархалт, байршил, тоо толгой, үржил, үүрлэлт, өндөглөлтийн судалгааны ажил хийсэн. Үүний дагуу 3 удаагийн давтамжтайгаар тураг гогойны үржлийг зогсоох ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн Буйр нуурын эрэг орчмыг цэвэрлэсэн байна. Гүйцэтгэгч аж ахуйн хүлээлгэн өгөх хүсэлтээ тайлангийн хамт ирүүлээд байна.	100
140	4.2.22.Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын төвийн ундны усны чанарыг сайжруулна.	Жилдээ 60 сая	Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангагдсан байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 60,0 сая төгрөгийн зардлаар 2017 онд Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын төвийн гүний худагт цэнгэгжүүлэх, цэвэршүүлэх тоног төхөөрөмж, ухаалаг худгийн тоног төхөөрөмж суурилуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Баялаг говь” ХХК дээрх 3 сумын төвийн худагт цэнгэгжүүлэх төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан. Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 6 сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн.	100
141	4.2.23.Чойбалсан хотод нийтийн эзэмшлийн газарт хөрс орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.	Жилдээ	Хөрс орчны бохирдол буурсан байна.	Чойбалсан хотод нийтийн эзэмшлийн газарт хөрс орчны бохирдлыг бууруулах /Хэрлэн сум 6 дугаар баг Ивээл хороолол/ ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.4-т заасны дагуу “Хан шонуу” ХХК-тай шууд гэрээ байгуулан ажиллаж, нийтийн бие засах байгууламж /контейнер/ иж бүрдлийг хийж дуусган, хүлээлгэж өгөх хүсэлтээ ирүүлээд байна. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/468 дугаар захирамжаар ажлын материал хүлээн авах ажлын комисс байгуулагдан ажиллаж байна.	100
142	4.2.24.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, түймрийн зурвас татах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилдээ	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил эрчимжсэн байна.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай аймгийн Засаг даргын А/165 дугаар захирамжийн дагуу Баян-Уул сумын Ульхан боомтоос баруун тийш Хэрийн гол хүртэл ОХУ-тай хиллэдэг хил дагуу Баян-Уул суман дахь Хилийн 0275 дугаар анги 107 километр, Дадал суман дахь Хилийн 287 дугаар анги 46 километр, нийт 153 километр урттай, 10 метрийн өргөнтэй түймрийн зурвас татах, сэргээх ажлыг хийж гүйцэтгэснийг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авсан. Булган суманд түймрийн зурвас татах ажлыг эрх шилжүүлж “Дорнын наран өндөр” ХХК 60 километрийн урттай, 10 метрийн өргөнтэйгээр гүйцэтгэсэн бөгөөд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авсан.	100
143	4.2.25.Яхь нуурын байгалийн нөөц газарт нэвтрэх журам боловсруулж батлуулна.	Жилдээ	Байгалийн нөөц газрын хамгаалалтын дэглэм, журмын хэрэгжилт сайжирна.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлд заасан “Байгалийн нөөц газрын дэглэм”-ийн дагуу зохицуулагдахаар заагдсан тул журам боловсруулах шаардлагагүй.	Үнэлэх боломжгүй

4.3 Аялал жуулчлалын салбарын мэдээллийн хүртээмжийг сайжруулж, маркетинг судалгааны ажлыг эрчимжүүлэн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх замаар жуулчдын тоог өсгөн дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.					
144	4.3.1.Халхгол, Баян-Уул суманд аялал, жуулчлалын маршрут дагуу мэдээллийн төв, түр зогсоол, амралтын цэг байгуулан тэмдэгжүүлэлт хийж тохижуулна.	2,3 дугаар улирал	Аялал жуулчлалын зориулалттай мэдээллийн төв, түр зогсоол, амралтын цэг байгуулан тэмдэгжүүлэлт хийж тохижуулсан байна. Түр болон байнгын ажлын байр нэмэгдэж, оршин суугчдын өрхийн орлого нэмэгдэнэ.	Буйр нуурын эрэг орчмыг хамгаалах, тохижуулах зорилгоор түр буудаллах цэг байгуулах ажлыг “Дорнын их дөл” ХХК гүйцэтгэхээр аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газартай 2017-III-17 тоот гэрээг байгуулан ажиллаж, 8 дугаар сард хүлээлгэн өгөөд байна. Онон голын аялал жуулчлалын маршрут дагуу мэдээллийн төв, түр зогсоол, амралтын цэг байгуулж, тохижуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Дорнод аймгийн Баян-Уул сумын Заяат багийн иргэн Ж.Батхүү БУ/БОХ/2017/01 тоот гэрээг байгуулан ажиллаж, 8 дугаар сард хүлээлгэн өгсөн.	100
145	4.3.2.Аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүдийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, гарсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.	Жилдээ 35 сая	Салбарын зөвлөгөөн зохион байгуулагдсан байна.	Орон нутагт аялал жуулчлалын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх арга туршлагыг солилцох, хамтын ажиллагааг сайжруулах, Төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй бодлого шийдвэр, цаашдын хөгжлийн чиг хандлага, салбарын хүрээнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, санал зөвлөмж гаргах зорилготой “Орон нутагт аялал жуулчлалын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх нь” зөвлөгөөнийг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан. Зөвлөгөөнд Байгаль орчин аялал жуулчлалын дэд сайд, аймгийн Засаг даргын орлогч, Байгаль орчин аялал жуулчлалын Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Дорнод Аялал жуулчлалын нэгдэл болон Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөлөл, аялал жуулчлалын бизнес эрхлэгч нийт 156 төлөөлөл оролцсон.	100
146	4.3.3.Хавирга, Баянхошуу хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх замын орох гарах урсгалыг тус бүр 2 болгон нэмэгдүүлэх талаар санал санаачилгатай ажиллана.	Жилдээ	Холбогдох байгууллагуудад санал хүргүүлж, судалгаа хийгдсэн байна.	Хилийн боомтоор нэг талдаа өдөрт дунджаар 70-80 тээврийн хэрэгсэл, ачаалалтай үед 100-150 тээврийн хэрэгсэл нэвтэрч байна. Боомтийн авто замын урсгалуудыг нэмэгдүүлэхэд анхаарч орц, гарцын тойм зураг, тооцоолол бүхий төслийг боловсруулсан.	70
147	4.3.4.Түүхийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилготой "Эрдэм шинжилгээний бага хурал" зохион байгуулна.	Жилдээ	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж түүхтэй холбоотой нэр бүхий газруудыг тогтоосон байна.	“Дорнод аймгийн аялал жуулчлал-инноваци” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2017 оны 4 дүгээр сард аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, “Аялал жуулчлалын нэгдэл” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний хуралд Монгол улс, БНХАУ-ын эрдэмтэн судлаачдын Дорнод аймгийн газар нутаг дээр болж байсан түүх, соёлтой холбоотой, нийт	100

				17 илтгэл хэлэлцэгдэж, хурлын үеэр инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргасан. Профессор О.Сүхбаатар Дорнод аймгийн нутаг дэвсгэрт 8 газар Их Монгол Улсын түүхтэй холбоотойг судлан тогтоож, тэмдэглэгээ хийх шаардлагатай байгааг танилцуулсан. Мөн хуралд оролцогчид Өүлэн эх төрхөм нутгийг Сэргэлэн сумын 4 дүгээр баг Очир хүрээний энгэр, Сүмийн булгийн хойд талд гэж тогтоон шав тавьсан.	
148	4.3.5.Хилийн боомтуудыг түшиглэн байгалийн болон түүх, соёл аялал жуулчлалын бүс нутаг тогтоож, газар эзэмшүүлэх, бүс нутаг тус бүрийг ашиглах журам боловсруулж мөрдүүлнэ.	Жилдээ	Бүс нутгуудын хил зааг тогтоогдсон байна.	Хилийн боомт бүхий Баян-Уул, Чойбалсан сумдад 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын зориулалтаар газар төлөвлөгдөөгүй, Чулуунхороот суманд 2 га газар, Халхгол суманд 1 га газар төлөвлөгдсөн байна. Түүх, соёл аялал жуулчлалын бүс нутгийг ашиглах журмын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авахаар ажиллаж байна.	40
149	4.3.6.Хөрш зэргэлдээ 3 улсын Аялал жуулчлалын өдрийг зохион байгуулна.	Жилдээ	Аялал жуулчлал, бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа бүхий арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	Хөрш зэргэлдээ 3 улсын Аялал жуулчлалын өдрийн арга хэмжээг 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Хугацаа болоо гүй
150	4.3.7.Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, ТББ-уудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах санал санаачилгыг дэмжиж, хамтын ажиллагааг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Нэгдсэн зохион байгуулалтад орсон байна.	Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “ITM-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “Улаанбаатар-2017” дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж оролцуулан “Дорнод аялал жуулчлалын нэгдэл”-ийн үйл ажиллагааг дэмжин талбайн түрээс, үзэсгэлэнгийн талбайн тохижилтын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн хамтран ажилласан.	100
151	4.3.8. Аймгийн баяр наадмыг Аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох зорилгоор Наадмын нээлтийн үйл ажиллагааг Хүннү гүрэн болон Их Монгол улсын түүх өгүүлсэн агуулгатай болгон зохион байгуулна.	Жилдээ	Наадмын арга хэмжээг аялал жуулчлалтай холбон зохиомжтойгоор зохион байгуулсан байна.	Ардын хувьсгалын 96 жил, Дорнод аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн баяр наадмыг 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Дорнод аймаг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн дээд шагнал Сүхбаатарын одонгоор шагнагдсантай холбогдуулж баяр наадмын өргөн хүрээтэй зохион байгуулсан. Наадмын нээлтийн үеэр хөдөөгийн 13 сумын төлөөллийг өв уламжлал, түүх соёлоо харуулсан байдлаар баярын жагсаалд оролцуулж, наадмын талбайн гадна талд сумд гэр барьж, гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг дэлгэн сурталчилсан.	100

152	4.3.9. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот дахь Монгол улсын Консулын газар, Дорнод аймгийн ЗДТГ-ын хамтын ажиллагааг эрчимжүүлж, Монгол улсад аялах БНХАУ-ын иргэнд олгох жуулчны визийг түргэн шуурхай олгодог болгох талаар судална.	Жилдээ	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот дахь Монгол улсын Консулын газар татан буугдсан тул хамтран ажиллах боломжгүй болсон. Монгол улсад аялах БНХАУ-ын иргэдэд олгох жуулчны визийг Бээжин, Хөх Хот дахь Ерөнхий Консулын газар, Эрээн дахь Консулын газруудаар олгож байна. Дорнод аймагт аялах БНХАУ-ын иргэнд олгох жуулчны визийг түргэн шуурхай олгодог болгох талаар судалгааг хийж, хүсэлтээ Гадаад хэргийн яаманд хүргүүлсэн.	100
153	4.3.10. Аялал жуулчлалын маршрут тогтоож баталгаажуулна.	Жилдээ	Маршрут баталгаажсан байна.	2009 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-т Дорнод аймгийн аяллын үндсэн болон туслах маршрутуудыг батлуулсан байдаг. “Аялал жуулчлалын салбарын мастер төлөвлөгөө” боловсруулах ажлыг аймгийн төсвийн 35,0 сая төгрөгний санхүүжилтээр судалгааны баг гүйцэтгэж байна. Гэрээний дагуу 11 дүгээр сарын 15-нд судалгааны ажлыг хүлээлгэн өгнө. Төлөвлөгөөний төсөлд 3 чиглэлийн 8 төрлийн аяллын маршрутыг шинэчлэн тогтоож тусгасан.	70
154	4.3.11. Дорнод аймгийн аялал жуулчлалын “Брэнд таван бүтээгдэхүүн”-ийг бий болгох талаар судална.	Жилдээ	Дорнод аймгийн брэнд бүтээгдэхүүн бий болно.	Дорнод аймгийн аялал жуулчлалын маршрутыг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор байгалийн аяллын төрлөөр Буйр нуур, Онон гол, тусгай сонирхлын аяллын төрлөөр шувуу ажиглах, ангийн аялал, түүхийн аяллын төрлөөр Туг уул, Хэрлэн барсын богинын маршрут, Гурван улсын уулзвар цэг зэрэг аяллын маршрутуудыг судалж байна. Буйр нуурын эрэгт хамгаалалтын байр, түр буудаллах цэг, хогийн түр цэг, жорлон, мөн Баян-Уул суманд хамгаалалтын байр, аялал жуулчлалын мэдээллийн төвийг ашиглалтанд оруулсан. Цаашид дээрх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана.	40
155	4.3.12. Жуулчдад үйлчлэх төрийн байгууллагуудын үйлчилгээг боловсронгуй болгоно.	Жилдээ	Төрийн үйлчилгээ шуурхай нээлттэй, хүртээмжтэй болсон байна.	Хилийн 0132 дугаар анги, аймгийн Засаг даргын дэргэдэх Гаалийн газарт Хавирга, Баянхошуу хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх замын орох гарах урсгалыг тус бүр 2 болгон нэмэгдүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн. Үүний үр дүнд Хавирга боомтоор шалган нэвтрэх хугацааг багасгах зорилгоор Хил хамгаалах ерөнхий газраас Жи-Мобайлын шилэн кабелийн сүлжээнд холбогдон зорчигчдын нэвтрэх хугацааг 2 минут болгон багасгасан. Хавирга хилийн боомтын шалган нэвтрүүлэх урсгалыг нэг дахин нэмэгдүүлж 4 зэрэг штамп дарж зорчигчдыг хилээр нэмэгдүүлэн ажиллаж байна.	70
156	4.3.13. ОХУ, БНХАУ өөрийн орны иргэд, жуулчдыг харилцан зорчуулахдаа хэрэглэдэг хялбаршуулсан арга хэлбэрийг судална.	Жилдээ	Хилийн боомтын үйл ажиллагаа түргэн шуурхай, өргөжсөн байна.	Орон нутгийн аялал жуулчлалыг дэмжих зорилгоор “Алтай тур Бюро” ХХК, “Тал нутгийн хэрлэн” ХХК-иудын урилгаар хил орчмын бүс нутагт аялахаар Хавирга, Баянхошуу боомтуудаар зорчиж буй гадаадын иргэдэд жуулчин ангиллаар орох зориулалттай 1 удаагийн визийг Гадаадын иргэн, харъяатын ерөнхий газрын Зүүн бүс дэх газар олгож байна.	70

Дундаж үнэлгээ

83,9

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР